

НҮҮДЭЛЧДИЙН БҮС ТҮҮНИЙ ХУВЬСАЛ ӨӨРЧЛӨЛТ

Д.Эрдэнэбаатар¹, Ц.Одбаатар²

¹ ШУА-ийн Түүхийн хүрээлэн, Улаанбаатар Их сургууль

² Улаанбаатар Их Сургууль

Түлхүүр үг: Бүс, агсарга, буган хөшөө, хүннү, түрэг, монгол

Монголын эртний түүх сударын мэдээ, угсаатны зүйн судалгааны үр дүн зэргийг анхааран үзвэл Монголчууд бүсийг эрхэмлэн үзэж, хүний сүлд хийморь, амь настай холбон үзсэн ойлголт төсөөлөл ахуйн болон оюуны соёлын хүрээнд нэлээд баттай байр суурь эзэлдэг юм.

Энэ утгаар нь бүс эрхэмлэх ёс заншилыг монголчуудын оюуны-соёлын хүрээнд тусгайлан судалж үзэх шаардлага зайлшгүй хэрэгтэй бөгөөд бүсний үүсэл гарал, түүний үүрэг зориулалт, хувьсал өөрчлөлт монголчуудын хувьд ямар байсан, монгол нутагт явуулсан археологийн судалгааны явцад бүстэй холбоотой археологийн дурсгалыг хэрхэн яаж судалсан, бүс нь нүүдэлчдийн ахуй амьдралд ямар үүрэг зориулалтайг судлах зорилго тавьсан болно.

Манай орны нутаг дэвсгэрээс илэрч олддог археологийн дурсгалуудын дотор эртний нүүдэлчдийн бүстэй холбоотой дурсгал нь ихэнхидээ буган чулуун хөшөө хийгээд хүн чулуун хөшөөнүүд дээр тохиолддог бөгөөд энэ төрлийн дурсгалуудыг тусгайлан судалсан судлаачид бүсний хэлбэр маяг, төрөл, зориулалтын талаар Оросын археологич В.В.Волков “Оленные камни Монголии” (1981 он) бүтээлдээ Монгол нутагт оршин байдаг буган чулуун хөшөөний дүрслэлд тулгуурлан, хүрэл зэвсгийн үеийн эртний овог аймгуудын хэрэглэж байсан бүсний хэв маягыг төрөл, хэлбэрийг ангилалд оруулан хэрэглээний зориулалтыг байлдааны болон ахуйн хэрэглээний зэвсэг багаж зүүж явах зориулалттай болохыг нь харуулсан байдаг.

Аажимдаа эртний нүүдэлчдийн бүс нь зөвхөн хэрэглээний зориулалтаар бус гоёл чимэглэл, нийгмийн доторхи зэрэг зиндааг илэрхийлэх билэг тэмдэг болон боловсронгуй болохын хирээр бүсний ур хийц улам сайжирч үнэт зүйл буюу алт, мөнгө, хүрэл, үнэт чулуун чимэглэл бүхий арьс шир, бөс даавуу зэрэг материалаар хийсэн бүстэй болсон төдийгүй бүсний зориулалт нь гоёлын, ахуйн, дайн байлдааны гэх мэтээр өөр өөр болсон байна. Бүс нь нийгмийн зэрэг зиндаа илэрхийлэх, зориулалт нь олон хэлбэр болж өөрчлөгдсөн үе МЭ-ний Y-X зууны үе буюу эртний түүхийн Түрэг-Монголын үе хэмээх хугацаанд бололтой байгаа нь энэ үеийн археологийн гол үндсэн дурсгал болох хүн чулуун хөшөөнүүдийг Монгол нутагт тусгайлан судалсан археологич, шинжлэх ухааны доктор Д.Баярын бичсэн “Монголын төв нутаг дахь түрэгийн хүн чулуу” (1997 он), “Монголчуудын чулуун хөрөг (XIII-XIV зуун)” (1995, 2002 он) зэрэг бүтээлүүдээс харахад тодорхой болж байна.

Эртний Монголчуудын өвөг хийгээд өнөөгийн монголчуудын хэрэглэж байсан буюу хэрэглэж байгаа бүс зөвхөн гоёл чимэглэл, нийгмийн зэрэг зиндаа илэрхийлэх зүйл бус тэдний нүүдэллэн амьдрах нөхцөл байдал зохицсон хувцас хэрэглэлийн чухал бүрэлдэхүүн болж байдаг байна. Учир нь хол аянд эсвэл байнга морин дээр шогшуулах, цогиулах зэргээр явах үед бүс нь хүний дотор эрхтэнийг морины явдал дунд доргиохгүй хамгаалж байдаг учраас эрүүл ахуйн үүднээс хүртэл авч үзэхэд хүртэл хамгийн чухал хэрэгтэй зүйл болох нь тодорхой байна.

Монгол нутагт элбэг тохиолддог янз бүрийн хэлбэртэй, өөр өөр цаг үед холбогдох эртний булшнуудаас нүүдэлчдийн хэрэглэж байсан бүс археологийн малтлагаар цөөнгүй илрэн олдож байжээ. Археологич Д.Навааны мэдээнүүдээс харахад эртний монголчууд хүрэл, мөнгө, алтан тоногтой буюу дан дээрх зүйлээр хийсэн бүс хэрэглэж байсан нь тодорхой байна.

Манайд эртний нүүдэлчдийн хэрэглэж байсан бүсний талаар дээр дурьдсан эрдэмтдийн дурьдсан бүтээлүүдийг эс тооцвол тусгайлан судалсан нэгэн сэдэвт бүтээл хомс бөгөөд Оросын судлаач Н.В.Добжанскийн бичсэн "Наборные пояса кочевников Ази." (1992) бүтээл судлаачдын сонирхол их татдаг төдийгүй Монголд ч энэ төрлийн судалгааг тусгайлан хийх нь зүйтэй санагдаж байна.

Эрдэмтдийн судалгааны бүтээл, тэдгээрийг нягтлан үзвэл нүүдэлчдийн бүсний хамгийн эртний дурсгал нь хүрэл зэвсгийн үед холбогдож байна. Монгол нутаг дахь буган чулуун хөшөөг судлан үзсэн Оросын эрдэмтэн В.В.Волков нэгэн сэдэвт зохиолдоо буган чулуун хөшөөнд сийлсэн бүснүүдийн хээг анхааран, тэдгээрийн адил төстэй ба олон янз байдлыг тодорхойлон /10: Табл. 114/ улмаар зүүсэн зэр зэвсгийг тус бүрт нь төрөлжүүлэн ангилсан байна¹. Оросын эрдэмтэн Э.А.Новгородова мөн буган чулуун хөшөөн дэх бүсний дүрслэврийг нягтлан түүнийг хээ угалзны олон төрлийг В.В.Волковын нэгэн адил гаргажээ².

Монгол нутаг дахь төмрийн түрүү үеийн түүхэнд холбогдох эртний бүсний олдворууд нь Увс аймгийн Улаангом хотын дэргэд дэх Чандмань уулын булш оршуулгын материалаас илрэн олдсоноор мэдэгдэж байгаа бөгөөд тэдгээрийг археологич, доктор Д.Наваан³, Д.Цэвээндорж⁴ нар судлан шинжилж ангилал хийн эрдэм шинжилгээний хэд хэдэн өгүүлэлдээ тодорхой дурджээ.

Оросын эрдэмтэн А.В.Давыдова Өвөр Байгаль дахь Хүннүгийн үед холбогдох зарим булшийг малтан шинжилж гарсан иж бүрэн тоноглол бүхий бүсийг тодорхойлсон ба Иволгийн суурингаас гарсан бүсний ялтас, даруулгыг судалжээ⁵.

Манай нэрт эрдэмтэн Г.Сүхбаатар Монгол нутаг дахь эртний нүүдэлчдийн зарим төр улсуудын тухай нэгэн сэдэвт хэд хэдэн зохиол туурвисан билээ⁶. Тэрээр хүннү нарын тухай нэгэн сэдэвт зохиолдоо холбогдох бүсний дурсгалуудыг гоёл чимэглэл, урлагийн талаас нь нягтлан үзжээ. Түүнчлэн хүннү нарыг залгамжлан Төв Азид өөрсдийн төр улсыг байгуулан явсан Сяньби хэмээх нэргийг хятад сурвалж бичгүүдийн эртний эртний дуудлага, бичлэгийг харьцуулан судалсны үндсэн дээр бүсний гаралтай нэр болохыг тогтоожээ.

МЭ ҮI зууны дунд үеэс Түрэгүүд Төв Азийн түүхийн тавцан дээр хүч түрэн гарч ирсэн билээ. Түрэгийн түүхэнд холбогдох түүх соёлын дурсгал Монгол нутагт нэн арвин бөгөөд түүний дотор булш оршуулгын байгууламж, хүн чулуун хөшөөд томоохон байр эзэлдэг. Өгүүлэгдэн буй үед холбогдох бүсний хэлбэрүүд чухамхүү дээр дурьдсан судалгааны эх хэрэглэгдэхүүнд хадгалагдан үлдсэн нь эрдэмтдийн судалгаагаар тодорхой байна.

Оросын эрдэмтэн В.Д.Кубарев эртний түрэгүүдийн үед холбогдох Алтай дахь хүн чулуун хөшөөдийг судалсан нэгэн сэдэвт зохиолдоо тэдгээрийн бүсний дурсгалд анхааран улмаар түүний засал чимэглэл, ялтас даруулганы олон янз байдаг онцлогт тулгуурлан зургаан хэв шинжид ангилан үзжээ⁷.

Археологич Н.Сэр-Оджав Эртний Түрэгүүд⁸ номондоо Монгол нутаг дахь Түрэгийн үеийн хүн чулуун хөшөөдийн бүсийг маш нарийн тодорхойлон бичжээ. Тэрээр Монголын Монголын зүүн өмнөд бүс нутгаар түгээмэл байдаг исэр суудал бүхий Дарьгангын өвөрмөц хүн чулуун хөшөөдийг хожуу үед холбогдуулах санал тавьсан ч Түрэгийн хүн чулуунд хамааруулан авч үзжээ. Харин доктор Д.Баяр

¹ В.В.Волков. Оленные камни Монголии. УБ. 1981

² Э.А.Новгородова. Древняя Монголия. М. 1989

³ Д.Наваан. Новые находки "зверного стиля" Монголмн. Археология и Этнография Монголия. Новосибирск. 1978

⁴ Д.Цэвээндорж. Чандманская культура. Археология и этнография Монголии. Новосибирск. 1978

⁵ А.В.Давыдова. Иволгинские археологические комплексы. Иволгинский могильник. Санкт Петербург. 1996

⁶ Г.Сүхбаатар. Сяньби. УБ. 1972, Монголчуудын эртний өвөг. УБ. 1980

⁷ В.Д.Кубарев. Древнетюркские изваяния Алтая. Новосибирск. 1990

⁸ Н.Сэр-Оджав. Эртний Түрэгүүд. УБ. 1970

Монгол нутаг дахь хүн чулуун хөшөөдийг тусгайлан судалж нэгэн сэдэвт бүтээл хэд хэдийг туурвижээ⁹. Тэрбээр, өвөрмөц хийц бүхий Дарьгангын тэдгээр хүн чулуун хөшөөдийг дундад эртний монголчуудын үед буюу XIII-XIV зууны үед хамруулж бүсний дурсгалыг нь ч анхааран үзсэн байна.

Мөн Археологич Н.Сэр-Оджав нэгэн сонирхолтой санал дэвшүүлсэн ба энэ нь түрэгийн үеийн археологийн дурсгалыг дан ганц түрэгийн үетэй холбон авч үзэхээс татгалзаж өмнөх үе Нирун /Жужан/ -д хамааруулсан явдал юм. Тэрээр түрэгийн үед холбогдоно гэж үздэг зарим дурсгал тухайлбал: олон унжлагатай агсарга бүс нь Жужанчуудын хойчис гэж үздэг, Азиас Дунай мөрний сав нутаг нүүдэллэн очсон Аварын булш оршуулганаас олноороо олддогийг тэмдэглэжээ¹⁰.

Эртний нүүдэлчдийн бүсний дурсгалыг судлахад археологич, доктор Д.Наваан ихээхэн хувь нэмэр оруулсныг тэмдэглэх нь зүйтэй. Тэрээр хүннү, түрэг, дундад эртний монголчуудын үед холбогдох булш оршуулгын байгууламжаас хэд хэдэн иж бүрэн тоноглогдсон бүсний дурсгалууд олж илрүүлсэн нь бидний судалгааны гол эх хэрэглэгдэхүүн болж байна¹¹. Үүнд : Дархан хотын Хонгорын САА –н нутаг Салхит өртөөний дэрэгдэх хүннүгийн үед холбогдох хүрэл бүс, Дархан хотын дэрэгдэх Бууралын уулнаас иж бүрэн тоноглол бүхий бүс, Говь Алтай аймгийн Алтай хотын дэрэгдэх Түрэгийн үеийн булшнаас мөнгөн бүс, Улаанбаатар хотын дэргэдэх Сонгино Хайрхан уулын салбар Дадарт уулнаас дундад эртний монголчуудын үед холбогдох алтан бүс, Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг дахь Бага арцатын амнаас мөн үед холбогдох зэс бүс олдсоныг дурьдаж болно.

Төв Азиар аялан явж байсан жуулчид, элчин төлөөлөгчдийн тэмдэглэл нь нүүдэлчдийн нийгмийн амьдрал, зан суртахуун, эдийн ба утга соёлын дурсгал түүний дотор бүсний дурсгалыг тодруулах чухал сурвалжийн нэг болдог. Тухайлбал: Ромын Папын зарлигаар Монгол нутагт ирж байсан Плано Карпинийн зохиолд тухайн үеийн нүүдэлчдийн цэрэг эрсийн зэр зэвсэг тэдгээрийг хэрхэн үйлдвэрлэж хийдэг тухай нарийн тодорхой тэмдэглэсэн¹² байдаг бол Марко Поло Хубилай хаан албан тушаал, өндөр хэргэм зэргийн илэрхийлэл болгон шадар хишигтэн цэргүүддээ алтан бүснүүдийг бэлэглэж байсан тухай тэмдэглэн үлдээжээ¹³. Жуулчидын тэмдэглэлийн гол үнэ цэнэ нь түүхэн хэрэг явдалд биеэр оролцож нүдээр харснаа бичиглэн үлдээсэнд байдаг бөгөөд дээр дурьдсан тодорхой баримтууд нь нүүдэлчдийн нийгэм дэхь бүсний үүрэг зориулалт, түүнийг эрхэмлэн дээдлэх ёсны үлэмж сонирхолтой мэдээг агуулсан тул судалгааны чухал сурвалжийн тоонд зүй ёсоор тооцогдож байна.

Дундад эртний Монголчуудын түүх соёлын гайхамшигт дурсгал болох "Монголын нууц товчоо"-нд бүсийг эрхэмлэх зан үйлтэй холбоотой сонирхолтой баримт цөөнгүй бий. Нүүдэлчдийн хувцасны нэг гол хэсэг нь бүс байгаад зогсохгүй XIII зууны үеийн Монголын хаад ноёдууд, угсаа сурвалж, эрх мэдлийн билэг тэмдэг болгож алтан бүс бүсэлдэг байсан тухай мэдээ нэг бус удаа бий¹⁴.

Азийн нүүдэлчдийн бүсний дурсгалыг цогцолбороор судалсан хүн бол Оросын эрдэмтэн В.Н.Добжанский юм. Тэрээр нэгэн сэдэвт зохиолдоо Өмнөд Сибирь, Төв Азийн нүүдэлчдийн бүсний дурсгалыг буган чулуун хөшөөний үеэс YI-X зууны үеийн түрэгийн үе хүртэл бүхэлд нь нэгтгэн авч үзэж дүгнэлт өгсөн

⁹ Д.Баяр. Монголын төв нутаг дахь Түрэгийн хүн чулуу. УБ., 1997. Монгол Алтайн хүн чулуун хөшөө. Д.Эрдэнэбаатарын хамт. УБ 1999, Монголчуудын чулуун хөрөг. УБ., 2002

¹⁰ Н.Сэр-Оджав. Монголын эртний түүх. УБ., 1977

¹¹ Д.Наваан. Бага арцатын амны Монгол булш. УБ., 1983, Дорнод Монголын хүрлийн үе. УБ., 1975, мөн Новые находки "зверного стиля" Монголии. Археология и этнография Монголии. Новосибирск., 1978

¹² Плано Карпини. Монголчуудын түүх. УБ., 1988

¹³ Марко Поло. Орчлонгийн элдэв сонин. УБ., 1988

¹⁴ Ц.Дамдинсүрэн. Монголын нууц товчоо. УБ., 1990 103,117,238-р зүйл

байна¹⁵. Гэхдээ тус зохиолд Монгол нутаг дахь нүүдэлчдийн бүсний дурсгалыг төдийлөн авч үзээгүйг тэмдэглэх хэрэгтэй.

Японы судлаач Шибэ Рёотаро зохиолдоо нэгэн сонирхолтой баримт дурьджээ. Энэ нь хүннүгийн бүсний төмөр арлыг хожим нь XIX зууны европын цэргийн даргын хувцаст хэрэглэгдэх болж түүгээр ч үл барам дайны үед Японы хуурай замын ахлагчаас дээш тушаалын хүмүүс хэрэглэх болсон ба нэг ёсны цэргийн дарга болохыг илтгэх тэмдгийн нэг болж байсан¹⁶ гэжээ.

Монгол нутаг дахь нүүдэлчдийн бүсний хамгийн эртний дурсгал нь хүрэл зэвсгийн үед холбогдож байгаа болно. Бидэнд олдож анхны эх сурвалжууд бол Монгол нутаг дахь хүрэл зэвсгийн үеийн томоохон дурсгал болох дараах хадны сүг зургуудад бүс дүрслэгдэн үлджээ. (1-р зураг) Тухайлбал:

Увс аймгийн Давст сумын нутаг Мөнгөт цахир хэмээх хадан уулын агуйн амны хадны зураг. Энэ зурагт цааш хараад зогсож буй хүний зурагнаас харахад дээлээ чанга, жавхайтал нь бүсэлсэн нь мэдэгдэж байна.

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутаг Бага-харганатын бууцны зүүн хойно буй хаданд нэг нохой есөн адуу нэг хүний дүрсийг сийлжээ. Дээрээсээ гурав дахь томоор дүрсэлсэн (азарга) адууны ард урт дээл гутал бүхий нум сум саадаг агссан эрийг нилээд тод томруунаар дүрсэлжээ. Уг хадны зурагт дүрсэлсэн хүн бүстэй байгаа нь тодорхой байна. Энэ нь нум сумыг бүрэн эзэмшсэн мал аж ахуйг эрхлэн хөтлөх болсон цаг үед тухайлбал хүрлийн өмнөхөн үед холбогдоно.

Баянхонгор аймгийн Бууцагаан сумын нутагт орших Гурван мандал уулын хаданд хоёр хэсэг зураг байх ба эхнийх нь МЭӨ II мянган жилээс МЭӨ I мянган жилийн тэргүүн хагаст холбогдоно гэж үздэг. Энд элдэв ан гөрөө адуу, тэмээ, нохой мөн нум сумаар ан гөрөө хийж буй хүмүүс адгуус амьтныг гаршуулан сургаж буй сэдэв байхаас гадна нум сум, байлдааны сүх, тэрэг, буйл, бурантаг зэргийг дүрсэлсэн нь сонирхолтой юм.

Өгүүлэн буй үеийн соёлыг бүтээгчдийн оюун санаа, уран сэтгэлгээний биелэл болсон буган чулуун хөшөөнд бүс цөөнгүй дүрсэлсэн байдаг. Буган чулуун хөшөөний бүснүүд нь үлэмж баялаг хээ угалз, янз бүрийн дүрсээр чимэглэгдсэн ба түүнээс олон төрөл зүйлийн зэр зэвсгийг зүүж сийлсэн байдаг тул тэдгээрийн онцлог байдал, хээ угалз, дүрсийн хэв шинжийг тодруулж болохуйц байдаг юм.


Архангай аймгийн Хайрхан сумын нутаг Хөшөөтийн талын 1-р буган чулуун хөшөө. Тус хөшөөний өндөр 2.48 м, өргөн нь 0.7 м, зузаан нь 0.38 м, хөшөөний бүс нь 15 см өргөн бөгөөд ташуу параллель зураасуудаар геометрийн дүрс үүсгэн чимжээ. Хөшөөний баруун талд нь бүснээсээ байлдааны сүх, гурван ширхэг гархинаас зүүсэн хоромсог унжуулж хойд талд нь сэнжтэй хутга зүүж, дундаа дугариг бүхий таван өнцөгт бамбай дүрсэлжээ.

Мөн аймгийн Эрдэнэмандал сумын нутаг Жаргалантын 7-р буган чулуун хөшөө. Тус хөшөөний өндөр 2.4 м, өргөн 0.4 м, зузаан нь 0.3 м тус хөшөөн дэх бүс нь ямар нэг чимэглэлгүй боловч өвөрмөц онцлог нь бүсээ хоёр давхар гурван шулуун зураасаар гаргажээ. Хөшөөнд баруун талд нь кинжал ба жирийн хутга, зүүн талд нь нум сумын саадаг дүрсэлсэн байна. Үүнтэй нэгэн адил дүрслэл бүхий Их тамир сумын Шавартын амны 1-р буган чулуун хөшөө. Тус хөшөөний урт 3 м өргөн нь 0.46 м, зузаан нь 0.35 м. Бүсийг эгэл жирийн байдлаар 10.5 см өргөнөөр уралсан байна. Бүсний хойд талд нь хос гох бүхий дэгээ, сэнжтэй хутга, өмнө талд нь таван өнцөгт бамбай, зүүн талд нь кинжал хутгын хамт дугариг толь, бэл, баруун талд нь байлдааны сүх, нум саадаг зэргийг зүүж дүрсэлжээ.

Баянхонгор аймгийн Жаргалант сумын нутаг Хиригсүүрийн дэнжийн 8-р буган чулуун хөшөө. Хөшөөний урт 3.1 м, өргөн нь 0.7 м. Бүс нь ямар нэг чимэглэлгүй бөгөөд 7 см өргөн байна. тус хөшөөнд олон төрлийн зэр зэвсэг дүрсэлсэн нь ихэд сонирхолтой бөгөөд хөшөөний баруун талд бариул ба толгойн

¹⁵ В.Ч.Добжанский. Наборная пояса кочевников Ази. Новосибирск., 1990

¹⁶ Ш.Рёотаро. Тал нутгийн тэмдэглэл. УБ., 1997 16-17-р тал



Зураг 1. Хадны зурагт бүс дүрслэгдсэн байдал

а. Увс аймаг Зүүнхангай сум. Зураагийн Улаан хад
б. Увс аймаг. Давст сум. Мөнгөт цахир

тус газар нь сэнж бүхий байлдааны сүх, сэнжтэй хутга, нум сум, саадаг, хос гохтой дэгээ, зүүн талд нь таван өнцөгт бамбай түүний доор гурвалжин зэвтэй урт жад мөн хануур жад, араатны толгойн бариул бүхий кинжал дүрсэлжээ.

Говь Алтай аймгийн Бугат сумын нутаг Дунд нуурын 2-р буган чулуун хөшөө. Урт нь 2.2 м, геометрийн болох гурвалжин дүрсээр олон дахин давхарлаж чимэглэсэн гоёмсог бүстэй. Бүсний өмнө талд нь гох дэгээ хутганы хамт, хоёр талд нь байлдааны сүх, кинжал, хутга зүүж дээд талд нь сум сойсон нумыг том дугариг толиний хамт дүрсэлсэн байна.

Хөвсгөл аймгийн Мөрөн хотын дэргэдэх Уушгийн өвөр дахь 7-р буган чулуун хөшөө. Тус хөшөө нь газар унасан боловч ил харагдах талд нь үлэмж олон цэргийн тоног хэрэгсэлийг дүрсэлжээ. Геометрийн гурвалжин дүрсээр чимэглэсэн бүстэй, нүүрэн талын хэсэгт байлдааны сүх, кинжал хутга зүүлгэж, дээд талд хоромсого нум сум хоёрыг тус тусад нь дүрсэлжээ. Хажуу талд нь хос гох бүхий дэгээг мөн зүүсэн байна.

Мөн тэндэх 3-р буган чулуун хөшөө. Урт нь 1.80 м, өргөн нь 0.7 м, зузаан нь 0.14 м тус хөшөөний бүс нь бусад буган чулуун хөшөөнийхөөс ихэд өвөрмөц өөрөөр хэлбэл хоёр давхар бүс мэт сийлж, тус бүрт нь геометрийн гурвалжин дүрсээр чимсэн нь онцлог байв. Хөшөөнд цагирган сэнжтэй ганц хутгыг зүүн талд нь дүрсэлжээ.

Завхан аймгийн Отгон сумын нутагт орших буган чулуун хөшөө өндөр нь 3.3 м, геометрийн жишүү гурвалжин (ромбо) хэлбэрийн чимэгтэй бүс. Нүүрэн талд нь дэгээ, хутга, хойд талдаа таван өнцөгт бамбайтай зүүн талд нь кинжал хутга, баруун талд нь байлдааны сүх дүрсэлжээ. Шилүүстэй сумын нутаг Дааган дэлийн 8-р буган чулуун хөшөө. Өндөр нь 2.8 м, өргөн нь 0.4 м, зузаан нь 0.33 м. тус хөшөөний бүсийг хоёр хөндлөн зураас татаж түүний хооронд нь замбараагүй олон зарим хэсэгт нь дөрөв дөрвөөр мөр зэрэгцүүлэн цэг бүхий дүрсээр чимэглэжээ. Зүүн талд нь чинжал баруун талд нь цагирган сэнжтэй хутга, бэл, таван өнцөгт бамбай, хойд талд нь дээрээ гурван цагираг дүртэй дахин нэг бамбай, өмнө талд нь байлдааны сүх бороохой дүрсэлжээ. Тэндхийн 7-р буган чулуун хөшөө. Өндөр нь 2.75 м, өргөн нь 0.4 м, урт нь 0.33 м тус хөшөө нь ямар нэг амьтны зураггүй боловч үлэмж олон зэр зэвсгийг бүсэндээ агсжээ. Үүнд: Өмнө талдаа цагирган сэнжтэй махир хутга, зүүн талдаа аварга том кинжал (урт нь 60 см), бэл, хоёр дугариг толбо бүхий бамбай, баруун талд нь сүх, саадагны хамт дүрсэлжээ.


Буган чулуун хөшөөн дэх бүсний чимэглэсэн байдлаас үзэхэд зарим нь ямар нэг чимэглэлгүй энгийн байхад заримд нь үлэмж олон хээ угалзаар чимж маш гоёмсог урласан байдал үзэгдэнэ. Бүс нь гурвалжин, жишүү дөрвөлжин, тэг дөрвөлжин хэлбэрийн гэх мэт геометрийн олон дүрс хэлбэртэй байхаас гадна хөндлөн, хос тахир, цэгэн, босоо, шулуун гэх мэт зураасуудаар янз бүрийн дүрс үүсгэж чимэглэсэн байна. Оросын эрдэмтэн В.В.Волков буган чулуун хөшөөнд давхардалгүйгээр 44 төрлийн дүрс, хээ бүхий бүс байгааг тогтоожээ¹⁷. (2-р зураг)

Буган чулуун хөшөөний дурсгалд дүрслэн үзүүлсэн нүүдэлчдийн бүсний дурсгалыг засаж чимэглэх тэдгээрийн онцлог байдлаар дүрслэсэн зэрэгт үндэслэж 4 хэв шинжид хуваан авч үзэж болмоор байна. Үүнд:

1. Гурвалжин, жишүү дөрвөлжин, тэг дөрвөлжин дүрсүүдийг хүрээ татаж түүндээ тасралтгүй үргэлжлүүлэн чимэглэж дүрсэлсэн бүс. Өөрөөр хэлбэл тус хэв шинжийн бүс нь геометрийн дүрсэн чимэглэлтэй бөгөөд нэлээд түгээмэл шинжтэй болохыг буган чулуун хөшөөдөөс ажиглаж болно.

2. Хүрээ татаж хооронд нь замбараагүй болон жигд дарааллаар цэг байрлуулсан бүс байна. Уг хэв шинжийн бүс нь Завхан аймгийн Шилүүстэй сумын нутаг Дааган дэл гэдэг газарт буй хэд хэдэн буган чулуун хөшөөнд байна.

¹⁷ В.В.Волков. Оленные камни Монголии. УБ. 1981., 117-р таблиц.



Зураг 2. Буган чулуу хөшөөнд дүрлэгдсэн бүсний хэлбэрүүд

3. Шугаман хүрээтэй ямар нэг дүрс чимэглэл үгүй цулгуй нэлэнхийд нь өнгөлсөн эгэл жирийн бүс байна. Ийм хэв шинжийн бүс нь нэг дэхь хэв шинжийн адил түгээмэл тохиолдож байгааг буган чулуун хөшөөдөөс харж болно.

4. Хоёр давхар буюу хос бүс. Ийм хэв шинжийн бүснүүд нь бусад дурсгалаас нэлээд өвөрмөц онцлогтой гэж үзэж Архангай аймгийн Эрдэнэмандал сумын нутаг дахь Жаргалантын 7-р буган чулуун хөшөө, Хөвсгөл аймгийн Уушигийн өвөр дэхь 3-р буган хөшөөдийг багтаан үзэж байна. Тус буган чулуун хөшөөдийн бүсний дурсгалыг шинжлэн үзвэл хүрэл зэвсгийн үеэс нүүдэлчин ард түмэн нийгмийн ахуй амьдралын хэрэгцээ шаардлагаар хос бүс хэрэглэж байсан гэж үзэж болно.

Хүрэл зэвсгийн үед буган чулуун хөшөөг хийхдээ том том нүсэр чулуудыг тээн авчиран нарийн уран сийлбэр хийж, чирэгдэл гарган тавьснаас үзэхэд овгийн жирийн гишүүдэд бус харин тухайн үеийн нийгмийн хамгийн нөлөө бүхий хүмүүст зориулан босгосон нь илэрхий юм. Иймд тэдгээр хүмүүсийн хамгийн эрхэм, урьд өмнө тухайн хүний нийгэмд эзэлж байсан байр суурийг илэрхийлэн гаргаж чадахуйц улмаар хойч үеийн хүмүүсийн үзэл сурталд нөлөөлөхүйц эд зүйлсийг буган чулуун хөшөөнд төлөөлүүлэн дүрсэлсэн гэж үзэж болмоор байна. Тэдгээрийн нэг нь бүс байсны хувьд түүнийг зориуд цохон тусгасан олон янз хээ угалз, зэр зэвсгийн зүйлсийг дүрсэлж байсан гэж үзмээр санагдана.

Буган чулуун хөшөөнд дүрслэгдсэн бүс нь хээ чимэглэлийн хувьд харилцан адилгүй өөр өөр байдаг боловч түүнээс зүүсэн зэр зэвсэг нь ихэвчлэн цэрэг дайны зориулалт бүхийг ихэд тод томруун дүрсэлсэн нь улмаар бүсийг дээл хувцас бэхлэх зориулалтаар ч бус зэр зэвсгийг биедээ байнга бэлэн авч явах үүргийг давхар гүйцэтгэсэн гэлтэй. Тиймд энэ үеийн бүсний ихэнх нь цэрэг дайны зоиулалттай цэргийн агсарга бүснүүд байсан нь буган чулуун хөшөөний дүрслэлээс тодорхой харагдаж байна.

Оросын эрдэмтэн А.А.Формозов "Хар тэнгисийн умард талын нүүдэлчин ард түмэнд бороохой, таяг, бүс, байлдааны сүх зэрэг нь тухайн овог аймгийн удирдагчдын засаглалын гол шинж тэмдэг байсан" гэж үзсэнийг В.Н.Добжанский иш татжээ¹⁸

Хэрвээ ингэж үзвэл Төв Ази дахь буган чулуун хөшөөнд дүрслэгдсэн зэр зэвсэг болон бүс нь мөн үеийн эрх мэдэл засаглалын гол шинж тэмдэг байсан нь эргэлзээгүй юм. Энэ үеэс эхлэн эртний нүүдэлчдийн дунд бүсийг эрхэмлэн шүтэх явдал бий болж улмаар зан үйлд тусгалаа олсон нь хойч үедээ уламжлагдан ирснээс тодорхой байна.

Хүрэл зэвсгийн үеийн бүсний дурсгал буган чулуун хөшөөнд тодорхой тусгагдан үлдсэн атал өгүүлэгдэн буй үед холбогдох булш оршуулгын байгууламжаас төдийлөн олддогүй нь анхаарал татаж байна. Энэ нь дөрвөлжин булшны соёлыг үлдээгчид бүсэндээ ямар нэгэн металл ялтас, товруу хэрэглэдэггүй гэсэн хэрэг биш бөгөөд харин ихэвчлэн бүснийхээ ширэн дээр зурж хээлэн чимэглэдэг байсан байж болох юм.

Хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булшны дурсгалаас, олон үет төвгөр чимэглэл бүхий бүсний чимэглэл хөндөгдөөгүй байдлаар олдож байсан бөгөөд энэ бүс нь жирийн хүн хэрэглэж байсан бололтой бүс байдаг¹⁹.

Монгол нутаг дахь төмрийн түрүү үеийн дурсгалыг судлах ажлыг МЗТСХЭ-ийн хүрэл төмрийн түрүү үеийг судлах анги археологич, доктор Д.Наваан, Д.Цэвээндорж нарын удирдлагаар 1972-1974 онуудад Увс аймгийн Улаангом хотын дэргэдэх Чандмань ууланд хийж гүйцэтгэсэн билээ.

Төмрийн түрүү үед холбогдох бүсний дурсгалаас үзэхэд иж бүрэн тоноглогдсон бус, харин бүсний арал /нүүр/, зарим нэг товруу хэсэг хэсгээр олдсон байна. Гэхдээ тэдгээр арал, товруу нь одоогоор нүүдэлчдийн бүсний

¹⁸ В.Ч.Добжанский. Наборные пояса кочевников Ази. Новосибирск, 1990. 60-р тал

¹⁹ Д.Эрдэнэбаатар. Монгол нутгийн дөрвөлжин булш, хиригсүүрийн соёл. УБ., 2002. 20-30-р тал

дурсгалын хамгийн эртний хэв маягийг хадгалсан гэж үзэж болох төдийгүй, тухайн үеийн урлагийн хөгжлийн түвшинг тодорхой хэмжээгээр хадгалсан байдгаараа ихээхэн ач холбогдолтой юм. Доктор Д.Цэвээндорж төмрийн түрүү үед холбогдох бүсний олдворыг дөрвөн хэв маягт ангилж үзжээ. Үүнд:

Бугын сийлбэртэй бүсний ясан арал. Уг ясан аралны нүүрэн дээр салаа эвэртэй хөлөө эвхээд хэвтэж буй бугыг маш нарийн уртайгаар сийлснээс гадна хүзүү, их бие, гурвалжин зүрхэн хэлбэрийн, боомыг зэрэгцээ хөндлөн зураасаар чимжээ. Дурьдсан бугын нуруун дээр согоон толгой /хүзүүтэйгээ/ хүзүүний харалдаа доор гэдэргээ харан хэвтэж буй ямар нэг амьтныг тус тус уралжээ. Бүсний нүүр зууван хэлбэртэй 9.6 см урт, 3-4 см өргөн, 0.5 см зузаан, нарийн үзүүр нь бүхэлдээ өргөн үзүүрийн доод хэсэг сөлтөрсөн, түүний өргөн хэсгийн төвд 0.7х2.2 см зууван дугуй, дээд өнцөгт нь 0.5 см диаметртэй нэвт нүхтэйн гадна нарийн үзүүрийн сөлтөрхий хэсэгт мөн жижиг дугуй цоорхой байгаа нь мэдэгдэж байна.

Хөдөлдөггүй махир хэлтэй дөрвөлжин хэлбэрийн хүрэл арал

Хөдөлдөггүй шулуун хэлтэй хүрэл арал

Төмрийн түрүү үед холбогдох бүсний дурсгал хөдөлдөггүй, дээрээ махир хэлтэй хүрэл арал судалгаанаас үзэхэд их биш олдсоныг тэмдэглэх хэрэгтэй.

Хүрэл зэвсгийн эрин үеийн овог аймгуудын дараа Монгол нутагт шууд залган өөрийн соёлоо үлдээсэн Хүннүчүүд нь Төв Азид нүүдэлчдийн анхны төрт улсыг байгуулсан бөгөөд тэдний түүх соёлын ул мөр, уугуул Монгол нутагт төдийгүй хөрш зэргэлдээ ОХУ, Хятадын нутаг оронд гүн гүнзгий үлдсэн нь археологийн судалгаагаар тодорхой болсоор байна. Хүннүгийн баялаг эд өлгийн зүйлсийн хамт бүсний дурсгал цөөнгүй олдож буй нь санамсаргүй зүйл биш бөгөөд энэ нь буган чулуун хөшөөний буюу хүрэл зэвсгийн үеэс хүннүчүүдэд уламжлагдан ирсэн эдийн болон оюуны соёлын чухал өв гэж үзэж болно.

1968 онд Дархан хотын дэргэдэх Хонгорын САА-н нутаг Салхит өртөөний орчны нэгэн булшийг малтахад хүнийхээ араг ястай хамт 2 ш гонзгой дөрвөлжин зүйл 4 талдаа нүхтэй дөрвөлжин ялтсан даруулга бүхий хүрэл бүс олджээ.

Тус булшийг археологич Д.Наваан хүннүгийн үед холбогдуулан үзжээ. Дээрх хоёр ширхэг дөрвөлжин хавтгай чимгийг Х.Пэрлээ эртний нүүдэлчдийн харь улсад одох элч төлөөлгчдийн батламж тэмдэг болох пайз /гэрэгэ/ -тай холбон үзжээ. Бид бүсний чимэг гэсэн эрдэмтэдийн саналыг баримталж байна. Энэ нь 1-рт нүүдэлчдийн хэрэглэж байсан пайз /гэрэгэ/-ны уламжлагдан ирснээс үзэхэд тус пайзан дээрээ хааныхаа нэр төр суу алдрыг магтан сайшааж хааны зарлигийг бишрэн дагахыг шаардсан тусгай бичиг бичиглэдэг байв. Харин тус олдворт ямар нэгэн бичиг үсгийн зүйл үгүй.

Тус хоёр хавтгай чимэгийн анх олдсон байдлаас үзэхэд хүнийхээ ташааны яс орчим хоёр талд нь байрлуулж тавьсан байжээ. Мөн тус чимэг нь голдоо цоолборлосон болон дээд талд нь суран оосор орох жижиг нүхтэйгээс гадна амьтны загварт урлаг тодорхой тусгалаа олсон нь маш сонирхолтой юм. Тухайлбал чимэг тус бүрт 6 ширхэг араатны толгойг дүрсэлжээ.

Өвөр Байгалийн Дэрст хэмээх газраас олдсон хүннүгийн үед холбогдох оршуулгын байгууламжийг малтан шинжилэхэд 38-р булшнаас араатан дүрсэлсэн хүрэл товруу 2 ширхэг, 2 жижиг цагираг, нарийн ур хийцтэй 2 том цагираг, 5 ширхэг даруулга ялтас, жижиг хонх, зүүлт чимэг бүхий иж бүрэн тоноглогдсон хүрэл бүс олджээ.

Ноён уулын 6-р булшны малтлагын дүнд хүннүгийн өөр нэг хэлбэрийн бүс гарсан бөгөөд энэ нь зуувандуу хэлбэрийн хүрэл цагиргаар чимэглэсэн суран бүс байсан гэж үздэг.

Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын нутаг Дуулга уулын 9-р булшнаас олдсон чимэглэл нь алтан шармал байсныг эрдэмтэд тогтоожээ.

Хүннүгийн бүсний арал, ялтсан дээрх чимэглэл нь дүрслэлийн сэдэв агуулгаараа хоорондоо ихэд адилсаж байгаа нь зүй ёсны бөгөөд үүнд: Дархан хотын дэргэдээс олдсон бие биенээ хэмлэлдэн тэмцэлдэж байгаа хоёр морь Иволгийн суурингаас олдсон хоёр бар болон лууны тулаан Ордосын хүрэлд буй хүч үзэн барилдаж байгаа хоёр хүний дүрстэй зэргийг дурьдаж болно. Эдгээр нь нэг төрлийн биесийг эсрэгцүүлэн сөргүүлэн тавьж дүрсэлсэн нь Дундад Ази дахь Кушаны соёлын үед холбогдох бүсэнд дээрх хоёр тэмээний ноцолдоон, хоёр баатрын халз тулаан зэрэгтэй ихэд төстэй болно. Хүннүчүүдийн оршин тогтнож байх үед тэдний соёлын нөлөө өмнөд Сибирь, Дундад Азид хүчтэй байжээ.

В.Н.Добжанский "Хүннүчүүдийн өрнө зүг дэх түрэмгийллийн хамт байнга нүүж байсан их нүүдлийн масс нь энэхүү аймгуудын /Дундад Ази, Өмнөд Сибирийн Д.Э/ соёлын материал дээр тухайлбал бүсний чимэглэлд мэдэгдэхүйц нөлөө үзүүлсэн" гээд "Енисей мөрний дунд хавийн сав нутаг дахь аймгуудад томоохон ялтсан даруулгууд хадгалагдан үлдсэн нь хүннүчүүдийн нөлөөг гэрчилж байна" гэж үзжээ. Оросын эрдэмтэн Ю.С.Худяков МЭӨ II зууны үед хүннүчүүд Дорнод Туркестаны нүүдэлчин аймгуудыг эзлэн авснаар тэдний соёлын нөлөө "Тухай бүс нутгийн хүн амын цэргийн тоноглол ялангуяа бүсний дурсгалд хадгалагдан үлдсэнийг тус нутаг дахь музейн үзмэрүүдээс харж болно" гэж үзжээ.

Дунь Хуан хотын музейн үзмэрт хүрэл цагираг зүүлттэй хагас зууван ба бөөрөнхий хүрээтэй хүрэл горхитой бүс, мөн тэгш өнцөгт хавтгай ялтсан тавлах нүх дөрөвтэй, хүрэл горхитой бүч байдаг байна. Үүнд тулгуурлан "Хүннүгийн соёлын нөлөө нь Өмнөд Сибирийн нүүдэлчин аймгуудад 200 гаруй жил байсан бөгөөд энэ нь төмөр горхи, цагирган унжлага, хонхон зүүлт зэргээр хурц илэрч байна" гэж Ю.С.Худяков үзжээ. Тува болон Хакас дахь нутагт хүннүгийн нөлөө удтал байсан нь хөдөлдөг хэлтэй төмөр арал, нарийн хийцтэй цагираг болон амьтны загварт урлагийн дүрсэлбэртэй товруунууд, жижиг хонхнууд, тэгш өнцөгт ялтастай хүрэл бүс зэрэг нь хүннүгийнхтэй үлэмж адилхан байгаагаас үзэхэд тодорхой байна. Хүннүгийн бүсний дурсгалаас үзэхэд хонх зүүх явдал нэлээд байдаг ба хонхыг зөвхөн бүсэнд төдийгүй морины тоног хэрэглэлд ч өргөн ашигладаг байжээ. Судалгааны хэрэглэгдэхүүнээс үзвэл хүрэл хонх нь Алтай /Орос/, Өвөр Байгалийн Дэрстийн Кутлуг, Иволгийн суурин, Монголын Ноён уул болон Умард Хятадын нутаг буюу Ордос зэрэг олон газраас олдсон байна. Археологич З. Батсайхан эдүгээ олдоод байгаа хүннүд холбогдох хүрэл хонхнуудыг хээгүй, цулгүй, хоёр талдаа хээтэй болон дөрвөн нүхтэй гэж ангилжээ. Оросын эрдэмтэн Б.Б.Дашибалов Дэрстийн булшнаас олдсон хүрэл хонхон зүүлт нь Курыканчуудад өргөн тархсаныг тэмдэглэжээ. Дээрхитэй адил хонх Амар мөрний сав нутаг дахь Зүрчидийн аймгуудын дунд байдаг бөгөөд ялангуяа хүүхдийн бүсэнд олноор зүүдэг байжээ.

Хүннүчүүдийн бүсний дурсгалд нүүдэлчдийн чимэглэлийн болон төмөрлөгийн урлагийн гайхамшиг болсон үлэмж нарийн ур хийц бүхий амьтны загварт урлаг тодорхой тусгалаа олсон байдаг. Монгол нутагт амьтны загварт урлаг хэдийд хэрхэн үүссэн тухай археологич Н.Сэр-Оджав "... Карасукийн уламжлалын бааз дээр амьтны загварт урлаг бүрэлдэн тогтож эхэлсэн бөгөөд энэ үеийн тал нутгийн мал аж ахуй эрхлэн суугчдын өвөрмөц урлагийн уламжлалт хэлбэр бүрэлдэн тогтсон үе байсан ..." гэжээ. Иймд хүннүчүүд амьтны зарварт урлагийг хүрэл зэвсгийн үеийн буган чулуун хөшөөг бүтээн босгогч өвөг дээдсээсээ уламжлан авсан гэж үзэж болно. Амьтны загварт урлаг нь Евразийн өргөн уудам тал нутагт нүүдэлчдийн соёл урлагийн нэгэн хэв маяг болж хөгжсөн нь зөвхөн гоёж чимэглэх гойд сайхан дүрслэх үүднээс биш нийгмийн шинж чанарын тусгал болсонтой холбоотой юм. Өөрөөр хэлбэл хүннүгийн бүсний дурсгал дахь амьтны загварт урлагийг тусгасан ялтсан даруулга, хүрэл товруу нь нийгмийн анги давхарга, зэрэг дэвийн тодорхой ялгарлыг тусган харуулсан нь ажиглагддаг.

Хүннү нараас хойш Монгол нутаг дээрхи археологийн дурсгалуудаас нүүдэлчдийн бүсний дурсгалыг нэлээд тодорхой дурсгал бол эртний Түрэгүүдийн үлдээсэн гоёл чимэглэл, төмөрлөгийн урлал, уран чадамгай дархчуудын ур дүйг илтгэн харуулсан иж бүрэн тоноглол бүхий бүсний олдвор цөөнгүй олдож байна.

Архангай аймгийн Эрдэнэмандал сумын нутаг дахь Дэрст ууланд Түрэгийн үеийн булшийг малтахад суран унжлагны нүх бүхий дөрвөлжин болон хагас саран хэлбэрийн ялтас, үзүүрийн даруулга төмөр, мөн горхи бүхий бүс гарчээ.

Дархан хотын дэргэдэх Буурал уулын энгэрийн 3-р булшнаас археологич Д.Наваан иж бүрэн тоноглол бүхий бүс олжээ. Тус бүсийг дундад эртний Монголчуудын үед холбогдуулсан боловч унжлага зүүлтний товруу, ялтас, даруулга зэрэг тоноглолыг нь харьцуулан шинжлэн үзвэл Түрэгүүдийн үед холбогдох төлөвтэй байна. Тус бүс нь маш нарийн ур хийцтэй бөгөөд ургамалын хээ бүхий тэгш өнцөгт дөрвөлжин ялтас 2 ширхэг, мөн адил хээтэй хагас саран хэлбэртэй ялтас 5 ширхэг, угалзалсан хээгээр хүрээлсний төв хэсэгт нь шувууны дүрстэй үзүүр төмөр, эвэр угалзтай аралнаас бүрдэж байжээ. Бүсний бүх ялтас нь суран унжлаганы нүхтэй байна.

Ховдын шинжилгээний анги 1990 онд Говь Алтай аймгийн Алтай хотын дэргэд нэг булш малтан шинжилж үзэхэд, уг булшнаас хүнийхээ биед иж бүрэн тоноглол бүхий мөнгөн бүс дагалдуулсныг олжээ. Тус бүсний тоноглол нь 6 дэлбээт цэцгэн хээ бүхий товруу 4 ширхэг, суран унжлаганы нүх бүхий тэгш өнцөгт ялтас 4 ширхэг, мөн адил зориулалттай хагас зууван ялтас ширхэг, үзүүрийн даруулга, суран унжлаганы үзүүрт бэхлэн хадах чимэг товруу 6 ширхэг, зуувандуу хүрээтэй хөдөлдөг хэлтэй арал зэргээс бүрдэж байжээ.

Түрэгийн үеийн бүсний дурсгалыг судлах өөр нэг судалгааны чухал хэрэглэгдэхүүн бол хүн чулуун хөшөө буюу чулуун хөшөөнүүд юм. Монгол нутаг дахь Түрэгийн хүн чулуу нь тус орны төв болон баруун хэсэгт төвлөрсөн шинжтэй байгаа нь Түрэгчүүд гол төлөв Орхон, Сэлэнгийн бэлчир, Алтайн нуруунд нутаглаж байсантай холбоотой юм. Эртний нүүдэлчдийн дунд өвөг дээдэс, алдар гавъяат үйлс бүтээсэн хүмүүстээ чулуун хөшөө босгох нь түгээмэл байжээ.

Археологич Н.Сэр-Оджав тэмдэглэхдээ "Хүрлийн хожуу үеэс нас барагсадынхаа булшин дээр хүний дүрсийг гаж болгон хийсэн буган чулуу тавих заншил Хүннү, Сяньби, Жужан, Түрэг нарт дамжин хүрч ирэхдээ хүний биет дүрсэд улам ойртон нарийссаар бүр Түрэгийн үед зөвхөн хүний дүрс гаргах төдий бус хувцас хунар, зэр зэвсэг, гоёл чимэглэлийн зүйлийг урлан хийдэг нэгэн загвар тогтсон байна" гэжээ. Түрэгийн бүсийг хамгийн тодорхой дүрсэлсэн дурсгал бол хүн чулуун хөшөө юм. МЭ-ний VI-VIII зууны үеийн Түрэгийн хүн чулуун хөшөөг урлан сийлэгчид нь тухайн хүнийхээ аль нэг онцлог нийгэмд эзлэх байр суурийг тодорхой тусгахыг хичээж байсан бөгөөд энэ нь бүснээс унжуулсан олон салаа унжлага, том жижиг хутга, сэлэм зэрэг зэр зэвсгийн зүйл хавтага сав зүүлгэсэн зэргээс тодорхой байна. Түрэгийн бүсний дурсгалыг ажиглахад маш нарийн уран чадмаг хийсэн байдаг нь дагнасан нарийн мэргэжлийн дархчууд байсан гэлтэй боловч аливаа бүсний гоёл чимэглэлийг хийхдээ тодорхой тогтсон хэв загварт баригдах явдал байсан бололтой. Тухайлбал, Түрэгийн бүсний дурсгал нь ихэвчлэн олон суран унжлагатай, дөрвөлжин ба тал саран хэлбэрийн ялтастай байдаг нь хүн чулуун хөшөө, булш оршуулгын материалаас үзэхэд тодорхой байна. Тэдгээр нийтлэг шинж тэмдэгт тулгуурлан Түрэгийн бүсний дурсгалыг 4 хэв маягт хуваан үзэж болох юм. Үүнд:

1. Дөрвөлжин буюу тэгш өнцөгт хэлбэрийн ялтастай бүс
2. Хагас саран хэлбэрийн ялтсан даруулгатай бүс
3. Цэцгэн хээ бүхий дугираг товруутай бүс
4. Дээрх гурван хэв шинжийг хослуулан чимэглэсэн бүс

Археологич Н.Сэр-Оджав "... Хүрэл, алт, төмрөөр чимэглэсэн агсарга бүс Жужанаас эхлэн Түрэгээр дамжин өргөн хэрэглэгдэж чичлүүр хутга, саадаг,

хоромсого зүүх тээглүүр, хавтага зэргийг зүүдэг унжуулсан суртай байсан нь булшнаас гарсан чимэг, хүн чулуунд сийлсэн бүс зэргээс мэдэгдэж байна” гэжээ.

Түрэгийн үед холбогдох бүсний дурсгалын нэг онцлог шинж бол түүнийг үлэмж их төмөрлөг ашиглаж хийсэн байдаг явдал юм. Эртний Түрэгийн язгуур аймгууд нь Алтайн ууланд сууж төмөрийн хүдэрийг хайлуулж дархлах ажил хийдэг байсан ба Жужаны хаант улсад төмрийн алба төлөхийн хамт 36 улс аймгийг төмөр эдлэлээр хангаж байжээ. Түрэгийн бүсний дурсгалыг шинжин үзвэл ихэвчлэн цэрэг дайны зориулалттай агсарга бүснүүд байна.

Эртний Түрэг – Монголчуудын дунд тахир махир шугамаар сүлжсэн хэлбэртэй долгион мушгиа чагт, эвэр навч, жимсгэнэ хэлбэртэй хээнүүд өргөн тархсан байна. Уг хээ нь Хүннү-Сарматын үед хөгжиж ирсэн бөгөөд энэхүү хээний дурсгалыг эдүгээ Азийн нүүдэлчин Түрэг угсаатан (Хакас, Киргиз) дунд хадгалагдан үлджээ. Мөн эртний Енисейн Киргизийн хээ нь одоогийн Хакасын төмөрлөг эдлэлийн хээтэй адил байна. Монгол нутагт оршиж байсан эртний Түрэгийн үед онцгой хөгжсөн төмөрлөг эдлэлд хээ цохиж гаргах болсон нь төмөрлөг эдлэлийг хээлэх аргын нэг үлгэр болсон байна.

Эртний нүүдэлчдийн бүс эрхэмлэх зан үйл нь үеэс үед бие биедээ уламжлагдан хадгалагдаж ирсэн нь дундад эртний монголчуудын үед холбогдох археологийн бодит олдвор бусад хэрэглэгдэхүүнээс тодорхой байна. Судалгаанаас үзэхэд дундад эртний монголчуудын булш оршуулгыг малтан судлахад нэг бус удаа алт, мөнгө, зэс, зэрэг өнгөт металлаар чимэглэсэн иж бүрэн тоноглол бүхий бүсний дурсгалууд олдсон байна.

Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг Бага Арцатын аманд археологич Д.Наваан дундад эртний Монголчуудын үед холбогдох нэгэн булшийг малтан шинжлэхэд, уг булшинд оршуулсан хүндээ зэсээр хийсэн эгэл хийцтэй бүс дагалдуулсан байжээ. Тус бүс нь үзүүрийн даруулга, хоёр ширхэг нарийхан даруулга /түдүүл?/, доороо сэнж бүхий хоёр ширхэг дөрвөлжин ялтастай, нэгийнх нь сэнж сэтэрхий, горхи нь хэлгүй боловч зуувандуу хэлбэртэй, сурандаа хадагдсан хавтгай төмрийн жижиг нүхээр хоорондоо тусгай төмрөөр бөгжлөгдөн холбогдсон ба даруулга ялтсанд чимэглэлийн ямар нэгэн хээ угалзны дүрслэл үгүй юм. Дундад эртний монголчуудын үед холбогдох язгууртны булш оршуулгыг малтан шинжилсэн судалгаанаас үзэхэд сонирхолтой эд өлгийн олдвор түүний дотор үнэт металл чимэг бүхий иж бүрэн тоноглогдсон бүсний дурсгал нэг бус удаа олдсон байна.

1959 онд Зөвлөлтийн эрдэмтэн С.В.Кислевийн удирдлагаар Онон мөрний дагуу монгол язгууртны булшийг судлан шинжилсэн юм. Энэхүү дурсгал нь эдүгээ ОХУ-ын Чита муж Онон мөрний сав Үрлүнгүй голын зүүн биед буй Хархираа голын хот хэмээх эртний Монголын хотын тууриас холгүй орших Окошки хэмээх ууланд буй болно. Энд буй язгууртны 4 булшнаас нэг нь тохиолдлоор тонуулчдын гарт өртөлгүй бүтнээр үлдсэн бөгөөд уг булш дээрээ чулуун дараас бүхий дотор талыг чулуугаар дүүргэсэн нүхэнд зузаан банзаар зааж хийгээд торгоор бүрж гадуур нь гурван төмөр бүслүүрээр бүсэлсэн авс бүхий оршуулга байжээ. Авсны таглаан дээр ясан дөрөө хэмээх модон эмээл, төмөр амгай зуузай бүхий хазаар, дотроо сумтай үйсэн саадаг, нум зэргийг тавьсан байжээ. Энэхүү авсанд 6 настай хөвгүүний шарил байсан бөгөөд торгон гадартай үстэй дээл хоргой малгай, торгон өмд цамц савхин гутал өмсгөсөн байв.

Онцлог нь язгууртны хөвгүүнийг оршуулахдаа цэрэг эрийн мөнгөн чимэгтэй агсарга бүс, түүнээс унжих хоёр хавтага савын хамт хийсэн байжээ.

Уг бүсний их биеийг ширээр хийж бүс оруулах түдүүл бэхэлгээндээ мөнгөн товруунууд сүвлэн оруулж тогтоосон байна. Эдгээр товруу нь мөлгөр булантай, дөрвөлжиндүү хэлбэртэй бөгөөд тойруулан хүрээ татаж голд нь үүлэн хээ болон хоёр шувууны дүрсийг мөн адил товойлгон гаргажээ. Тэдгээр товрууны хоёр нь хавтага бэхлэх зориулалттай тул доор нь оосор шургуулан уяж тогтоох сэнж хийжээ. Голын товруу нь бүсний гархины үүрэг давхар гүйцэтгэх учиртай тул хоёр

талдаа тал саран хэлбэртэй, хоёр товруу бэхэлдэг байсан нь өөр бусад дурсгалаас мэдэгдэх ба энд ганц ийм товруу хадгалагдан үлдсэн голдоо мөн товгор угалз хээтэй байна. Энд өгүүлэн буй бүс нь Монголчуудын бүтээсэн хүн чулуун хөргийн он цагийг лавшруулан тодотгох чухал баримтын нэг болж байгаагаараа туйлын үнэ цэнэтэй юм.

Дээрхи бүснээс хоёр ширэн хавтага зүүлттэй байсан нь олдсон бөгөөд тэдгээр хавтага нь хэмжээний хувьд яльгүй зөрөөтэй бөгөөд хэлбэр ижил гонзгой дөрвөлжин доороо мөлгөр булантай хаалтыг ирмэгийг угалзлан хайчилж доош дайруулан гол нь хошуурсан үзүүр гаргасан байжээ. Хаалтан дээр бүсний чимэгтэй ойролцоо хэлбэртэй товрууг бэхэлж гоёсон нь мөн угалзалсан товгор хээтэй хавтагануудын дээрээс хоёр нарийн оосор гаргаж бүсний товруунаас уяж бэхэлсэн байжээ. Эдгээр хавтагыг бусад дурсгалтай харьцуулж үзэхэд Дорнод Монголын хүн чулуун хөргүүдэд дүрсэлсэн хавтагуудтай тун адил бөгөөд хамгийн сонирхолтой нь дурьдсан чулуун хөргүүдэд ямагт хоёр хавтага бүснээс унжуулан дүрсэлдэг нь Мөн том бага хоёр байх ба томыг зүүн ташаанд нь, багыг нь баруун ташаанд нь зүүдэг байжээ.

1981 онд МЗТСХЭ-ийн түүх соёлын дурсгал судлах анги Улаанбаатар хотын дүүрэг Сонгинохайрхан уулын салбар Дадарт уулын энгэр биед нэгэн нууцлагдсан булшыг илрүүлэн малтахад дагалдуулсан эд, өлгийн хувьд онцлог зүйл олдсон байна. Уг булш нь гадаад шинжээр ерийн Монгол булшны байдалтай, намхан чулуун дараас бүхий 230 см гүн булшны нүхний хойд хажуу руу шургуулан хүний толгойг зүүн хойш хандуулан тэнэгэр байдлаар тавьж цогцыг бүтэн үйсээр ороон ус чийгнээс хамгаалсан байна. Нас барагчийн толгойд эмээлийн бүүрэгний хэсэг төмөр дөрөө хоёрыг 3 хөлт ширмэн тогооны хөлийн хугархай толгойн баруун талд нас гүйцсэн хонины дал, төмөр хутга, баруун ташаанд нь 65 см урт үйсэн саадагт гурван өөр хэлбэрийн төмөр зэв зэргийг дагалдуулсан байжээ. Мөн алтан тоног бүхий бүс дагалдуулан тавьсан нь Монгол нутгаас олдож байгаагүй ховор олдвор болно.

Бүсний алтан товруу 6 дэлбээт, цэцгэн хэлбэрт тав бүхий 2 хадаасаар бүсэнд бэхлэгдэж байсан 26 ширхэг товруу, эвэр угалз хээтэй цутгамал арал, хэлний сэнжийг битүү гагнасан угалзан хээтэй том хавчаар, хээгүй угийн хавчаар мөн бүсэнд бэхлэгдэж зүүгдэж байсан уул, усны долгион, ургамлын хээтэй ар талдаа бат бэх сэнжтэй, доороо цох хэлбэрийн алтан чимэг, түүний доор унжиж байсан мөн уул усны долгион хээтэй дундуураа тасруудсан хос маягтай гонзгой чимэг эдгээр бүгд 31 ширхэг том жижиг алтан чимгээс уг бүс бүрдэж байжээ.

Археологич Д.Наваан дээрхи алтан чимэглэлүүдийн дотроос зүрх маягийн зүүлт бол нас барагчийн эрхлэх албан тушаалын зэрэг дэвийг илэрхийлсэн онцгойлох тэмдэг байсан гэж үзжээ.

Сүүлийн жилүүдэд явуулсан судалгааны үр дүнд Дорнод Монголд байдаг олон тооны хүн чулуун хөргүүд нь дундад эртний монголчуудын үед холбогдох тогтоосон²⁰. Манай судлаачид дээрхи дурсгалуудыг Түрэгийн үеийн хүн чулуун хөшөөтэй харьцуулашгүй онцлог гэдгийг анхаарч цаг хугацааны хувьд өөр өөр үед холбогдоно гэдгийг нэг бус удаа тэмдэглэж байсныг дээр дурьдсан билээ. Тус дурсгал нь хувцас хунар, нүүр төрх, эдлэл хэрэглэл зэрэг олон шинж төрхөөрөө Түрэгийн үеийн хүн чулуун хөшөөн дэх дүрслэвэрээс эрс ондоо бөгөөд бид бүсний дурсгал нь тодорхой мэдэгдэж буй дурсгал бол XIII-XIV зууны Монголын үеийн хүн чулуун хөргүүд юм.

Дундад эртний монголчуудын хүн чулууны бүсэнд Түрэгийн үеийн хүн чулуунд өргөн тохиолддог дөрвөлжин ялтсан чимэг, зэр зэвсэг зүүхэд зориулагдсан олон тооны оосор, унжлага зэрэг огт тохидлохгүй байгаа нь онцлог юм. Тухайлбал, 3 хүн чулууны бүс нь ямар ч хээ угалз, товруу чимэг байхгүй, жирийн дөрвөлжин хэлбэрийн гархитай байхад, 5 хүн чулуун хөрөгт цэцэг хэлбэрт

²⁰ Д.Баяр. Монголчуудын чулуун хөрөг. УБ., 2002

гархитай, хагас саран буюу цэцгийн дэлбээ хэлбэрт товруун чимэгтэй гоёмсог бүс бүсэлжээ. Дээрхи бүсний дурсгалууд нь дундад эртний үеийн монголчуудын сурвалж бичгийн мэдээг археологийн олдвороор нотолж байгаа учир судалгааны ихээхэн ач холбогдол бүхий чухал хэрэглэгдэхүүн болно.

Эртний нүүдэлчдийн бүс эрхэмлэх ёсон нь гүн гүнзгий утга агуулгатай зан үйл байсан ба Төв Азид хүрэл зэвсгийн үеэс улбаатай болохыг судлаачид магадлажээ²¹. Тус зан үйл нь нүүдэлчдэд хэрхэн бий болсон нь ихээхэн сонирхолтой бөгөөд энэхүү бүсийг эрхэмлэн дээдлэх зан үйл бий болоход эрхлэн буй аж ахуй, өдөр тутмын ахуй амьдралын онцлог Төв Азийн цаг агаарын эрс тэс уур амьсгал, улмаар нийгмийн тодорхой хүчин зүйлс нөлөөтэй байсан бололтой.

Цаг агаарын хүйтэн сэрүүн нөхцөлд жавар салхинаас хамгаалж, биеийнхээ дулааныг хадгалахад дээл хувцсаа заавал бүслэх шаардлагатай байжээ. Түүнээс гадна байнга морин дээр явахад хүний дотор эрхтэн доргих явдал байдаг учраас бүс нь аажимдаа өргөн болж, хүний эрүүл мэндийн талаас хамгаалах үүрэг давхар гүйцэтгэх болсон билээ.

Хүрэл зэвсгийн дунд сүүл үе гэхэд Төв Азийн нүүдэлчид мал аж ахуйг нэгэнт баттай эрхлэх болж улмаар овгийн байгуулал аажмар задарч, хөрөнгө чинээний ялгаа эрс тэс гарч ирсэн үед эрчүүд ганзага нийлэх, малжин хөрөнгөжиж хоорондоо харилцан хэрэгцээний зүйлээр арилжих, солилцоо хийх, цэрэг эрсийн холбоо тогтоож цэрэглэх үйл явц эрчимтэй болж иржээ. Иймд нүүдэлчдийн нийгэмд цэрэг эрсийн үүрэг өндөрт тавигдаж магадгүй шийдвэрлэх үүрэгтэй болсон байна. Аливаа асуудлыг цэрэг дайны үйл ажиллагаагаар шийдвэрлэх нь түгээмэл болж ирсэн учраас цэрэг эрсийн зэр зэвсэг, хуяглал, хамгаалах хэрэгсэлд үлэмж анхаарах болсон нь цаашдаа бүсний үүрэг ач холбогдлыг үлэмж ихэсгэсэн байна.

Төв Азийн эртний нүүдэлчдийн бүсний хэв шинж нь цэргийн зориулалттай агсарга бүс байсан гэдэгт олонхи эрдэмтэд санал нийлдэг ба буган чулуун хөшөөн дэх бүсний дурсгалыг шинжвэл дайчин цэрэг эрсийнх болох нь илэрхий байдаг.

Бүснээс зүүх зэр зэвсгийн нэр төрөл олшрохын хэрээр, түүнийг тогтоон барих суран унжлага, гархины тоо нэмэгдэж байсан байна.

Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын нутаг Цагаан хөшөөтөөс олдсон Түрэгийн хүн чулуун хөшөөний бүсэнд 9 ширхэг унжлага дүрсэлсэн байжээ. Хүннү, Сяньбийн удмын нэгэн аймгийн ноён Хятадын хаанд 13 алтан гархи бүхий бүс бэлэглэж байжээ²². Энэ нь наад зах нь төдий тооны зэр зэвсэг, эд хэрэглэлийг зүүдэг байсан гэсэн үг юм.

Бүсний дурсгалаас үзэхэд нийгмийн түүхэн хөгжлийн явцад тухайн үеийнхээ хэрэгцээ шаардлагыг даган улам хувьсан өөрчлөгдсөөр ирсэн байна. Өөрөөр хэлбэл хос бүс бүслэх болсон ба нэг нь хувцсаа бүслэх нөгөө нь зэр зэвсгээ зүүх зориулалттай байсан бололтой. Судлаачид хос бүс бүслэх нь хаанаас уг сурвалжтайг нягтлан үзжээ. Үүнд: А.А.Гаврилов Кудыргын (Алтай) булшийг шинжилж үзээд Кудыргэчууд саадаг болон илдээ зүүдэг хоёр бүстэй байсан ба энэ нь тусгай эрх ямбатны шинж тэмдэг байсан гэжээ. Тэрээр мөн уг зан заншил нь Обь мөрний сав нутгийн дээд хэсэгт суудаг овог аймгуудад байсан гэж үзсэн байна²³.

Унгарын археологич Д.Ласль : Аварчууд хос бүс бүсэлдэг байсан, мөн И.А.Аржанцев: Хятадын элч төлөөлөгчид хоёр бүс бүсэлдэг байсан ба нэгийг нь ордондоо нөгөөг нь янз бүрийн эд зүйлтэй тухайлбал зэр зэвсэгтэй бүсэлдэг байсан гэж үзсэн судлаач байна²⁴.

²¹ БНМАУ-ын угсаатны зүй. I боть. УБ., 1987. 87-р тал

²² Г.Сүхбаатар. Сяньби. УБ., 1972. 77-р тал

²³ В.Н.Добжанский. Наборные пояса кочевников Ази. Новосибирск., 1990. стр.42

²⁴ А.В.Давыдова. Пояс с бронзовым ляшками из Дырестуйского могильника. Советская Археология. 1988. стр.43

Төв Азийн нүүдэлчдийн дунд хос бүс бүслэх зан заншил байсан бөгөөд энэ нь хүрэл зэвсгийн үеэс уг эхтэй гэж үзэж байна. Архангай аймгийн Эрдэнэмандал сумын нутаг Жаргалантын буган чулуун хөшөөнд бүсийг нь ямар нэгэн хээ угалзгүй гурван ширхэг шулуун зураасаар буюу хоёр давхар байдлаар урлажээ. Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутаг Уушгийн өврийн 3-р буган чулуун хөшөөн дүрсэлсэн бүсийг нь гурван ширхэг урт шулуун зураастай, тэдгээрийн хооронд геометрийн (ханан хээ) гурвалжин дүрсээр чимэглэсэн байна.

Доктор Д.Баяр Сүхбаатар аймгийн Онгон сумын Таван толгой гэдэг газарт буй дундад эртний монголчуудын хоёр хүн чулуун хөрөгний тольт бүсний дотор талаар нь өргөн даавуун бүс давхар бүслүүлж урласныг ажиглажээ²⁵. Азийн нүүдэлчин ард түмэн төмөрлөгт зэвсэгт шилжин орсон нь тэдний аж ахуйн болон нийгмийн хөгжилд үндсэн эргэлт болсныг ялангуяа бүсний дурсгалуудаас харж болно. Бүсийг тоноглохдоо (чимэглэхдээ) янз бүрийн төмөр эдлэлүүдийг өргөн ашиглах болсон нь түүнийг боловсронгуй болгож цаашдын хувьсан хөгжилтөд дэвшил болсон гэлтэй.

Хүннү нарын бүсний дурсгалаас үзэхэд “амьтны загварт урлаг”-ийн төрөлд багтах янз бүрийн загварчилсан амьтан бүхий хүрэл товруунуудыг бүсэндээ хадаж чимэх болжээ. Ер нь Хүннүгийн бүсэнд амьтны загварт урлаг маш хүчтэй тусгалаа олсон байдаг. Гэтэл Түрэгүүдийн бүсний дурсгалд амьтны загварт урлагийн шинж тэмдэг байдаг ч зонхилох болж чадахгүй харин дөрвөлжин ба хагас саран хэлбэр бүхий ялтаснууд түгээмэл болж ирсэн байна. Нүүдэлчдийн бүсний ялтаснаас нь эгэл жирийнхээс хүний оюун ухаан, уран сэтгэмжийг шингээсэн маш нарийн чимэглэгдсэн байдаг нь эртний нүүдэлчид төмөрлөгийн урлагийг чадамгай эзэмшсэн төдийгүй тэдний нийгмийн давхаргын харилцан адилгүй болон олон талт байдлыг харуулсан гэж үзэж болно.

Ер нь хээ угалзыг:

1. Цэцэг навчнаас гаралтай ургамал хээ
2. Огторгуйн элдэв дүрсээс үүдэлтэй геометр хээ
3. Дээрхи хоёрыг хослуулсан ургамал геометр хээ
4. Эрхэмлэн дээдэлж ирсэн үнэн бодит хийгээд уран зөгнөлөөр дэврүүлж буй болгосон үлгэр домгын амьтны дүрсээс гаралтай амьтан хээ
5. Ургамал-геометр-амьтан хээ
6. Тамга тэмдэгнээс үүсэлтэй гэж ангилсан байдаг ажээ.

Үндэстэн бүрийн хээний тогтолцоо, хээ бүтэх ёс нь адилхан байдаг. Ихэнхи хээг ажиглахад нэгэн бие дүрсийг олон дахин давтаж хээн тогтолцоонд оруулсан байна. Тэгш хэм болон хэмнэл нь урлагт төдийгүй байгальд ч байдаг гэж үздэг. Хэмнэл нь нэгэн орон зай цаг хугацаан дахь адил төстэй зүйрлүүлсэн үзэгдлийн давтагдах чанарыг хэлнэ. Тэгш хэм гэдэг нь тооны хэлээр бол “хавтгай дээрхи ямар нэгэн F дүрсийн цэгүүдтэй ямар нэг S дүрсийн шулууны хувьд тэгш хэмтэй орших бүх цэгүүдээс тогтсон F, дүрсийг F дүрстэй, S-ийн хувьд тэгш хэмтэй орших дүрс гэдэг. Иймээс ямар нэгэн биеийн дундаж тэнхлэгээсээ хоёр тийш толины тусгал мэт ижил хэмжээтэй байх дүрсийг хэлнэ. Тэгш хэм нь бие хэсгийг тэгш сайхан болгож төгсгөлгүй үргэлжлэн давтагдах хөдөлгөөнийг үүсгэнэ. Тэгш хэм бол гоо сайхны эх булаг. Биеийн гоо сайхан нь бие хэсгийн тэгш хэмэнд оршино. Хэмнэл, тэгш хэм хоёрын нийлэмж нь хээ угалзыг улам бодилог, хүний сэтгэл татахуйц болгодог байна.

Бүс нь түүхэн хөгжлийнхөө явцад олон үүрэг зориулалттай болсон байна. Бүсийг үүргийнх нь хувьд авч үзвэл доорхи үүргүүдийг шууд буюу дам байдлаар гүйцэтгэдэг байжээ. Үүнд:

1. Хувцасны үүрэг. Бүс бүсэлснээр хувцасыг биеэс хөндийрүүлж салгахгүй байх үүрэгтэй тул цаг агаарын тааламжгүй нөхцөл байдлаас хамгаалж биеийн дулааныг хадгалах үүрэгтэй.

²⁵ Д.Баяр. Төв Азийн нүүдэлчдийн исэр суудлын тухай. Түүхийн судлал. УБ., 1997. 46-р тал

2. Агуулах савны үүрэг

Дээл өмсөхөд цээжин биеийн эргэн тойронд дээлний дотуур зай гарах тул бага хэмжээний овор багатай зүйлийг агуулан явах боломжтой.

Яваандаа бүснээсээ хөдөлмөрийн болон байлдааны багаж зэвсгээ зүүж явах болсон нь гарны үүргийг хөнгөвчлөн хувцас гэхээсээ илүү нэг ёсны багажны үүргийг илүү гүйцэтгэх болсноор бүсний хөгжилд нэгэн шинэ үеийг авчирсан билээ. Энэ нь агсарган бүс болно

3. Нийгмийн зэрэг дэвийг илтгэх

Төр ёсны харилцааны хэрэглүүр өөрөөр хэлбэл, гэрээ хэлэлцээр андгай тангарагтаа бэлэн байхын бэлэгдэл.

Эрх мэдэл хүчийг илтгэх нэр төрийн баталгаа

4. Мэдээллийн үүрэгтэй

Хонхтой бүс. Хубилай хааны үед өртөө бүрийн хооронд гурван бээрийн зайд элч нар хэд хэдэн хонх зүүсэн өргөн бүс бүсэлж довтолгон явдаг тул дараачийн буухиа элч өртөөний бэлэн байдлыг хангахад дөхөмтэй.

Айлд бүс бүслэхгүй орох бэлэвсэрлийн үйл гүйцэтгэж буйг илтгэж буй хэрэг, мөн дээс бүслэн гэрт орох нь хүн өөд болсон эсвэл гэмтнийг баривчлах гэж буйн тэмдэг юм.

Бүсийг зориулалтаар нь

1. Ёслол хүндэтгэлийн бүс

2. Өдөр тутмын буюу ахуйн бүс

3. Ан ав, дайн байлдааны бүс

4. Хүүхэд болон эмэгтэйчүүдийн бүс гэж ангилж болох юм.

Эртний нүүдэлчин ард түмэн, дээл хувцасны дотроос бүсийг ихэд эрхэмлэн хүндлэн иржээ. Манай ард түмний үлгэр домог, цэцэн үг уран зохиолд амьдралын сайн сайхан, төр улсын баг амгалан, амар түвшинг малгай, дээл, бүс, гутал зэрэгтэй холбон үзэж ирсэн нь санамсаргүй зүйл биш юм. Тухайлбал, аливаа задгай таранхайг бэхлэн батжуулж салсан сарнисныг эвлүүлэн бүтээхийн утга бүхий гэж үзэж "бүтэх төрийн бүс" хэмээн хэлцдэг байжээ²⁶

Хүн төрөлхтөний түүхнээ улс байгуулж явсан ард түмний төрийн билгэдэл болгож ирсэн үндсэн зүйлс нь газар газрын үндэсний өвөрмөц онцлог зан суртахуун, ёс заншлыг тусгаж ирсний дээр хүн төрөлхтөний нийтлэг зүй тогтол ч байжээ.

Хүн төрөлхтөний нийтлэгийн нэг гол ялгараа болсон улс иргэнийг төлөөлөх онцгой тэмдэг нь тусгаар, эрх бүхий улс бүрийн билгэдэл болж байдаг. Тухайлбал: эртний Нанхиад оронд малгай бүс хэмээх ойлголт бол төрийн түшмэлийн тушаалд дэвших; эрх ямба ахихын билгэдэл болж байв. Эртний Перс оронд бүс, титэм, хаан ширээ гурвыг хаан төрийн билэг тэмдэг болгон үздэг байжээ²⁷

Нүүдэлчин ард түмэнд ч бүс нь төр ёсны билэг тэмдэг болж байсан нь сурвалж бичгийн мэдээнд тэмдэглэгдэн үлдсэн байна. XIII-XIV зууны үеийн Монголын эзэнт гүрний төрийг засах ухааны их бичиг "Дөрвөн төрийн арван буянт номын цагаан түүх" хэмээх хууль цаазын дурсгалт бичигт нүүдэлчдийн төрийн билгэдлийг албан ёсоор хуульчилан бичиж үлдээсэн нь ихээхэн сонирхолтой юм. Тус бичигт хаан хүний ёсон их билгийг тодорхойлжээ. Үүнд:

1. Түмэн цэрэг аялуулах хараа ихт хар туг бусдыг айлгахын бэлгэ

2. Хамаг бүгдийг хөдөлгөх хашгираа ихт улаан бүрээ хамтаар хүндлэхийн бэлгэ

3. Бие сахиx хүч ихт Алтан хуур бие сахиxын бэлгэ

4. Гэрэл сацрангуй шар шүхэр олонд өргөгдөхийн бэлгэ

5. Чийрэг ихт сайн алтан эмээл явдлын бэлгэ

6. Засаг явуулах хурц илд засаг явуулхын бэлгэ

²⁶ БНМАУ-ын угсаатны зүй. I боть. 154-р тал, ба Г.Сүхбаатар. Сяньби. УБ., 1972. 18-р тал.

²⁷ С.Г.Баталов. За Уралскай Гунний. II-IV вв. н.э стр. 45.

7. Ээл ихт хүнд бүс төр тогтоохын бэлгэ

8. Хүндэт суудлын өндөр тавцант исэр хүнд суудлын бэлгэ

9. Түшиг сайн өрлөгүүд арга билгийн бэлгэ гэжээ²⁸.

Дээрхи төрийн есөн билэгдэл нь зөвхөн монголчуудын төдийгүй нийт нүүдэлчдийн төр ёсны билэгдэл байсан гэж үзэж болмоор байна. Хятадын Линди хаан "Хүннү исэр"-т (Ху чуан буюу нүүдэлчдийн исэр) дуртай байсныг сударчид тэмдэглэн үлдээсэн байдаг. Ноён уулын 6-р булшийг Хүннүгийн Учжулюй шаньюйн булш гэж үздэг бөгөөд тус булшнаас шүхэрийн зарим нэг хэсэг олдсон ба умард Хүннүгийн Чжижи шаньюй 5 өнгийн тугтай байжээ²⁹.

Доктор Д.Баяр "Ху чуан" гэдгийг эрдэм шинжилгээний ном зохиолд "Хүннү исэр" гэж утгачлан орчуулсныг хянан үзэж "Ху гэдэг нэрээр нийт нүүдэлчдийг нэрлэж байсан тул нүүдэлчдийн исэр гэвэл илүү тохиромжтой" гэж үзсэн байна. Иймд исэр, туг, шүхэр зэрэг нь шаньюйн төрийн билэг бэмдэг болж байсан ба үүнээс гадна өөр зүйлүүд байсныг үгүйсгэх аргагүй юм.

Эртний дорно дахины хаадууд бие биедээ төрийн билэгдэл болдог зарим зүйлсийг бэлэглэдэг байсан байна. Энэ нь тухайн тусгаар улс орны төрийн билэг тэмдэг болж, тусгаар тогтносон бие даасан байдлаа илэрхийлхийн зэрэгцээ нөгөө талаар хөрш зэргэлдээ орны төрийн ёсыг хүндэтгэсэн ёслол, түүнийг хүлээн зөвшөөрсний шинж тэмдэг болж байсан гэлтэй. Ромын Папын элч П.Карпини өөрийн тэмдэглэлдээ 1246 онд Гүюгийг Их Монгол улсын хаан ширээнд өргөмжлөх төрийн ёслолд оролцсон, харь улсын хаадын өргөсөн бэлэг нь торгон хилэн магнаг хоргой эдлэл, үнэт чамин үслэг эдлэл, мөн Их хааны тэргүүн дээр барьдаг өвч сувд хатгамалсан шүхэр, алтан утас ороосон торгон бүс зэрэг байсныг дурьджээ³⁰. Ромын Папаас Юан улсын Хубилай хаанд алтан бүс илгээж байсан баримт бий³¹. Дундад эртний Монголчуудад төдийгүй Хүннү нарт ч Хятадын хаадаас төрийн их бэлгэнд алтан бүс оруулдаг байжээ.

Хятадын Хан улсын Сяо Вэньди хаан МЭӨ 174 онд Хүннүгийн Модун Шаньюйд илгээсэн захиандаа "алтан сиби нэг" гэх зэрэг олон зүйлийн бэлэг явуулснаа дурьджээ. Энэхүү сиби гэдэг нь бүс гэсэн утгатай үг болохыг магадлажээ³².

Овгийн байгууллын үед Америкийн Индиан аймгуудад бүс эрхэмлэх ёс түгээмэл байсан нь тэдэнд өөр фратрийн, аймагт элч төлөөлөгчөө илгээхдээ бүс илгээх, хэлэлцээ хийхдээ амласнаа биелүүлэх тэмдэг болгон хэд хэдэн бүс солилцох зэргээр бүсийг албан ёсны харилцааны билэг тэмдэг болгодог байжээ. Үүнтэй нэгэн адил Сяньби нар харь орнуудтай харилцахдаа гоёмсоглон хийсэн арал, гархитай бүс бэлэглэдэг заншилтай байсан байна. Үүнд Хүннү, Сяньби хоёрын аль алинтай нь шууд холбоотой бөгөөд Таньшихуайн үед түүний улсын зүүн гарт багтаж байсан Юй вэнийн ноён Ли Му МЭ-ний IY зууны сүүлчээр Сүй улсын анхны хаан Янь Цзяньд 13 алтан гархи бүхий бүс бэлэглэж байсныг³³ дурьдаж болно.

Эртний нүүдэлчид бүсийг төрийн билэгдэл болгож байснаас гадна ялангуяа дундад эртний монголчуудын хаад, язгууртнууд угсаа сурвалж, эрх мэдлийн билэг тэмдэг болгож алтан бүс хэрэглэж байсан тухай сурвалж бичгүүдэд олонтаа тэмдэглэж үлдээсэн байдаг³⁴.

Тухайлбал, XIII зууны үеийн Монголын түүх соёлын гайхамшигт дурсгал "Монголын Нууц Товчоо"-ны 117-р зүйлд "...Тэмүжин, Жамуха хоёр одоо бид

²⁸ Монгол ёс заншилын их тайлбар толь. Тэргүүн боть. УБ., 1992. 712-713-р тал.

²⁹ Г.Сүхбаатар. Сяньби. УБ., 1972. 57-р тал.

³⁰ П.Карпини. Монголчуудын түүх. УБ., 1988. 72-р тал.

³¹ Ж.Неру. Ертөнцийн түүхийг сөхөн үзвэл. УБ., 1989.

³² Г.Сүхбаатар. Сяньби. УБ., 1972. 77-р тал.

³³ Х.Пэрлээ. Монголын түүх судлах сурвалжийн нэг нь пайз мөн. Түүхийн судлал. УБ., 1976. 77-р тал.

³⁴ Ц.Дамдинсүрэн. Монголын Нууц Товчоо. 1990. 13-106

амраглаж явъя гэж Тэмүжин, Мэргидийн Тогтоагоос олзолж авсан алтан бүсээ Жамуха андад бүслүүлж, Тогтоагийн эсгил халиуныг Жамуха андад унуулав. Жамуха хариуд нь Дайр Үсүнээс олзолж авсан алтан бүсээ Тэмүжинд бүслүүлж мөн Дайр Үсүний эвэрт ишгэн цагааныг Тэмүжинд унуулав". Гэжээ. Дээрхи мэдээнд үндэслэн зарим эрдэмтэд монголчууд анд бололцохдоо бүс солилцдог байсан гэж үздэгийг эргэн харахад хүргэж байна.

Энэ нь юуны өмнө бүсийг өндөр эрх мэдлийн тэмдэг болгож дээдлэн ирсэн гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Ийм учраас Тэмүжин, Жамуха хоёр Мэргидийг дарж, толгойлогчдынх нь сүр хүчийг доройтуулан, алтан бүснүүдийг нь олзлон авсан байна. Улмаар талын язгууртнууд дунд өдөр ирэх тусам нэр хүнд, сүр хүч нэмэгдэн байсан тэр хоёр анд бололцох ёсыг дахин үйлдэхийн зэрэгцээ бие биесийн эрх мэдэл, сүр хүчийг харилцан хүлээн зөвшөөрч байгаагаар илэрхийлэхийн ялдраа, ялагдсан дайсныхаа "олзолсон" бүсийг солилцож байсан байж болох юм. Бөөгийн шашны үзэл ёсоор бол монголчууд төдийгүй нийт нүүдэлчдийн дунд, бүсэнд хүний сүр сүлд, хийморь оршдог хэмээн үзэж өрөөл бусадтай сольж бүслэхийг эрс цээрлэдэг билээ.

"Монголын Нууц Товчоо"-ны 238-р зүйлд, "Уйгурын Идүд хан: Чингис хаан соёрхвол алтан бүсний чинь гархинаас барьж ариун дээлний чинь үртэснээс олж тавдугаар хөвүүн чинь болж хүчээ өгье" гэж байжээ.

Улс төрийн бутралын сүүл үед монгол язгууртанууд алтан бүс хэрэглэж байжээ. Лу. "Алтан товч"-д: Алтан ургийн сурвалжит язгууртан болох жонон Баянмөнх, алтан бүс бүслэн явсан тул Юншээбү овгийнхон түүнийг таньж амь насанд нь халдсан гэж гардаг³⁵. Энэ нь хожуу үе хүртэл монголын ихэс дээдэс өндөр язгуур хүч чадал, эрх мэдлийн бэлгэ тэмдэг нь алтан бүс хэвээр байсны гэрч юм..

Дундад зууны Италийн алдарт жуулчин Марко Поло, Хубилай хаан нэг түм хоёр мянган хишигтэн цэрэгтээ тус бүрт нь сувд, тана, хийгээд бусад эрдэнийн чулуу шигтгэн хийсэн өнгө өнгийн үнэт сайхан хувцас 13, мөнгөн утсаар оёсон тэмээний ширэн гутал нэжгээд, эрхэм сайхан алтан бүс нэжгээдийг бэлэглэсэн тухай бичиж үлдээсэн байдаг. Эдгээр сурвалжийн мэдээнээс үзэхэд алтан бүсийг хэргэм зэрэг, албан тушаалын таних тэмдэг, нийгмийн доторхи язгуур өндөр, эрх мэдлийн билэгдэл болгож байсан нь эргэлзээгүй бөгөөд археологийн баримтаар ч давхар нотлогдож байгаа билээ³⁶. Эртний нүүдэлчид бүсийг хичнээн их хүндэтгэн эрхэмлэж ирсэн нь овог аймгуудын нэрэнд ч тусгалаа олсон байна. Түүхч Г.Сүхбаатар Хятад сурвалж бичгийг нягтлан "Сяньби гэдэг нэр нь бүсний арлыг нэрлэсэн нэр болох нь эргэлзээгүй" гэж тэмдэглэсэн байна³⁷. Монгол сурвалж бичигт Хорчин хэмээх аймаг нь улаан бүсний угсаа мөн бөгөөд язгуураас хааны гадаад ураг болох дээрээс хаан хадамлах, хатан залах зэрэг зүйл цөм Хорчиноос хадамлах нь тогтоогдсон хууль болно. Хорчины ноёд бол хааны нагац улаан бүсний угсаа³⁸ гэсэн нь угтаа улаан бүс гэдэг угсааныхан эртнээс үе дамжин ирсэн нь тодорхой байна. Кидан гүрний хувцасны хуульд заасан ёсоор хаан хүн тахилга, тайлгын ёслолд улаан өнгийн эдээр хийсэн бүс бүслэнэ³⁹ гэсэн байдаг нь сонирхолтой хэрэг бөгөөд цаашид судлууртай юм.

Бүс бол нүүдэлчдийн хувцас хэрэглэлээс малгайн дараа орох эрхэм хүндтэй хэсгийн нэг болж байсан нь түүнийг бишрэн шүтэх, хүндэтгэн эрхэмлэх зан үйл эдүгээ манай ард түмний дунд хадгалагдан үлдсэнээс харж болно.

Монголчууд бүсний дээр огт гишгэхгүй, дээгүүр нь алхах ч ёсгүй гэж үздэг. Унтахдаа бүсээрээ туулайн чих зангидаж, дэрэн доороо тавьдаг, мөн эр хүний

³⁵ Б.Б. Дашибалов. Хуны и Курыкани. Улан-Үдэ. 1996. стр.72

³⁶ Д. Наваан. Эртний Монголчуудын бүс эрхэмлэх ёсон. ОУМЭ ГҮ их хурал. III боть. 1986.

³⁷ Г. Сүхбаатар. Сяньби. УБ., 1972. 78-р тал.

³⁸ Г. Сүхбаатар. Сяньби. УБ., 1972. 130-р тал

³⁹ Х. Нямбуу. Хүндэлхийн дээд хөх Монголын төрийн ёсон. УБ., 77-р тал

хэрэглэж буй бүсэнд хүний сүлд хийморь оршдог гэж үздэг учраас өөрийн хэрэглэж буй бүсээ хүнд өгдөггүй байв. Тэр ч бүү хэл хүнтэй сольдоггүй нандигнан ирсэн нь уламжлагджээ. Мөн ёс суртахууны доголдол гаргасан болон нийгмийн эсрэг гэмт хэрэг өдүүлсэн хүнд ял шийтгэл оногдуулахад бүсийг нь тайлан авч дээлийг нь нөмөргөх, эхнэр хүнд бүс бүслүүлэхгүй байх зэрэг олон зан үйл бий.

Эдүгээ уламжлагдаж ирсэн дундад зууны үеийн хууль цаазын бичгүүдэд хүн амын өргөн хэрэгцээний хувцас хунар болон эдлэл хэрэглэлтэй холбоотой хэргийг хатуу шийтгэж торгууль оногдуулдаг байсан ба түүн дотор бүс багтаж буй нь санамсаргүй зүйл биш юм. Тухайлбал, Цогт хунтайжийн балгаснаас олдсон Халхын зургаан хошууны цааз эрхэмжийн бичигт заасан хэргийн бүрэлдэхүүнд гарах хувцас хунар, эд өлгийн зүйлсийн дотор нэхий, нэхий дээл, мөнгөн эмээл, мөнгөн худрага, "мөнгөн бүс", нумын хөвч, саадаг, булга, шилүүс, халиу, тарваган дах зэрэгтэй холбогдсон хэрэгт ял шийгэл оногдуулдаг байжээ⁴⁰. Түүнчлэн ямар шийтгэл оногдуулахыг тодорхой заажээ.

Эртний нүүдэлчдийн утга соёлын нандин өв болох аман зохиолын олон салаа мөчрөөр дамжин бидэнд уламжлагдан ирсний нэг нь ардын үлгэр домог байтарлаг туульс билээ. Тухайлбал, баатарлаг туульсаар дамжуулан эдүгээ монголчуудад буй уламжлалт олон зан үйл эртний нүүдэлчдийн дагаж мөрдөх нийгмийн хэм хэмжээ болж байсныг мэдэж болох төдийгүй аж амьдрал, хувцас, гоёл чимэглэл, зэр зэвсгийг ч тодруулах боломжтой юм. Жангарын хүлэг баатар Алаг улаан Хонгорын хувцасны тухай туульд:

Эрээн гэдэг цамцаа өмсөөд

Эрднийн гурван цээжмэгээ өмсөөд

Дайны өвч хуягаа өмсөөд

Далан морины үнэтэй төмөр луузан бүсээ бүслээд гэж гардаг.

Бас бугын годон тулман бүс гэж, "Эзэн улаан бодон" туульд өгүүлдэг нь ойн иргэдийн аж байдлыг эрхгүй санагдуулах ба саяхан болтол Хөвсгөлийн Цаатангууд бугын гоцыг зүсэж бүс хийн, туурайгаар нь үзүүрийн тээглүүр болгон бүсэлдэг байснаас үзэхэд ойн гөрөөчний энэ байдал, туужид гарах эртний нүүдэлчдийн аж байдал хадгалагдан үлдсэн нь харагдаж байна⁴¹.

Монголчуудын бүс эрхэмлэх зан үйл нь зүг чиг эрхэмлэх ёсонтой холбогдож байгаа нь сонирхол татаж байна. Дөрвөлжин булшинд нас барагчаа зүүн зүгт хандуулан оршуулдаг нэгэн нийтлэг заншил ажиглагддаг нь нар мандан гарах зүгийг эрхэм болгодог хүмүүсийн онцлог шинж юм. Үүнтэй холбогдуулан эртний нүүдэлчдийн ахуй амьдрал зүүн зүг, үүнээс баруун зүг эргэх ёсон гарсан нь дэлхийн эргэлтийн эсрэг зохицсон эргэлт бөгөөд одоо ч нар зөв эргэх билэгтэй эргэлт гэдэг⁴². Гэтэл энэ нь бүс бүслэхдээ нар зөв ороон бүслэхийг эрхэмлэдэг сонирхолтой ба маш эртний улбаатайг харуулна.

Нүүдэлчдийн бүсийг эрхэмлэх үзэл нь өнө эртний уламжлалтай төдийгүй амьдрал ахуйн онцлог, зан заншил, ертөнцийг үзэх үзэлтэй нь гүг гүнзгий уялдан, тусгалаа олж монголчуудын хувцасны соёлд шингэсэн байдаг.

Цаг хугацааны хувьд авч үзвэл монгол нутагт бүсийг дүрсэлсэн хамгийн эртний дурсгал нь Увс аймгийн Сагил сумын нутаг Мөнгөт цахирын хадны зураг (МЭӨ III-I мянгын) гэж үзэх саналтай байна. Хүрэл зэвсгийн сүүл үе гэхэд Төв Азийн нүүдэлчдийн дунд овгийн байгуулал задрах үйл явц эрчимжиж хөрөнгө чинээний ялгарал гарах болж нийгэмд эрчүүдийн байр суурь үлэмж нэмэгджээ. Энэ үеэс бүс нь нийгмийн давхаргын байр суурийг илэрхийлэх болсон байна. Үүнийг нотлох баримт гэвэл, Археологийн малтлагаар нэг булшнаас хоёр бүсний арал олддог нь тухайн үеийн хүмүүс хос бүс хэрэглэж нэгээр нь хувцсаа бүслэх, нөгөөгөөс нь зэр зэвсгээ зүүдэг байсан болов уу гэсэн дүгнэлтэнд хүргэж байна.

⁴⁰ Х.Нямбуу. Монгол хувцасны түүх. УБ., 2002. 66-р тал.

⁴¹ Х.Нямбуу. Монгол хувцасны түүх. УБ., 2002. 66-р тал.

⁴² Д.Наваан. Дорнод Монголын хүрлийн үе. УБ., 1975. 131-р тал.

Туайлбал хос бүслэх зан үйл нь Төв Азийн нүүдэлчдийн дунд хүрэл зэвсгийн үед анх бий болж хойч үедээ уламжлагдсан байна.

Мөн МЭӨ II мянган жилээс бүтээж эхэлсэн буган чулуун хөшөөнөө дүрсэлсэн бүсний дурсгалуудад түүнийг эзэмшигчийн нийгэмд эзлэх байр суурь, эрх мэдлийг зориуд цохон тусгасан олон янз байдаг бөгөөд мөн хээ угалзаар чимэглэж байлдааны олон төрлийн зэр зэвсгийг зүүж унжуулсан нь тал нутгийн дайчин эрсийнх болох нь эргэлзээгүй юм. Буган чулуун хөшөөнд байдаг нэг онцлог бол бүсний арлыг огт дүрсэлдэггүй бөгөөд бүсийг харьцангуй өргөн дүрсэлдэг явдал юм. Энэ нь даавуун төрлийн бүс байсан байж болох талтай. Буган чулуун хөшөөнд их дүрслэгддэг хөрөөний ир мэт хээгээр уул усыг дүрсэлсэн байж болно. Мөн Баянхонгор сумын Галуут сумын буган чулуун хөшөөнд могой дүрсэлсэн байсан нь уг хээгээр могойг ч дүрсэлсэн байж болох талтай юм.

Нүүдэлчдийн бүсний дурсгалыг шинжин үзвэл цэрэг дайны зориулалт бүхий цэргийн агсарга бүснүүд зонхилох боловч хээ угалзны чимэглэл дүрсэлсэн байдлаар холбогдох үеүдэд өөр өөр онцлог бүхий байна. Тухайлбал хүрэл зэвсгийн үед бүсний чимэглэл нь геометрийн хээ угалзаар чимэглэгдсэн байдаг ба Хүннү нарын үлдээсэн дурсгалд амьтны загварт урлагын нөлөө хүчтэй туссан байдаг. Харин Түрэгийн үед холбогдох бүсний дурсгалуудад буган чулуун хөшөөнүүдэд элбэг байдаг дөрвөлжин болон дугариг завь дүрстэй ялтаснууд элбэг үзэгдэнэ. Нөгөө талаар бүсний ялтаснууд хүний оюун санаа ухамсарт үйл ажиллагааг тодорхой шингээсэн байдаг учраас эгэл жирийнээс үлэмж нарийн урласан байдаг нь нүүдэлчид төмөрлөгийн урлагийг чадамгай эзэмшсэн төдийгүй нийгмийн ялгарал давхаргын харилцан адилгүй тэгш бус байдлыг тусган харуулсан гэлтэй.


Бүсний дурсгалаас үзэхэд нийгмийн түүхэн хөгжлийн явцад тухайн үеийнхээ хэрэгцээ шаардлагыг даган хувьсан өөрчлөгдсөөр ирсэн нь тодорхой байна. Эртний дэлхий дахины олон улс орнуудын нэгэн адил нүүдэлчдийн төрт улсууд өөрийн тогтсон төрийн билгэдэлтэй бөгөөд тэдгээрээс тухайлбал бүсийг гадаад ертөнцтэй харилцах төрийн албан ёсны харилцааны түлхүүр болгож ашиглаж ирсэн нь сурвалж бичгийн мэдээнүүдээр батлагдаж байна.

Нүүдэлчдийн ахуй нь хөдөлгөөнт амьдрал байдаг учир тэдэнд байлдааны байнгын бэлэн байдалд байх шаардлага урган гарчээ.

Тэрхүү шаардлага нь бүсний үүрэг ач холбогдлыг улам нэмэгдүүлхийн зэрэгцээ нэг ёсны "зэвсгийн" үүргийг давхар гүйцэтгэх болжээ. Эртний нүүдэлчдийн бүсийг хүндэтгэх үн үйлийн нэг илрэл нь түүнийг өндөр язгуур эрх мэдэл, засаглалын нэг гол шинж тэмдэг гэж үзэж ирсэн нь сурвалж бичгийн мэдээ, археологийн олдворуудыг нягтлан үзвэл эргэлзээгүй нотлогдож байна.

Бүсийг эрхэмлэх үзэл Монголчууд төдийгүй дорно дахины нүүдэлчдийн дунд нийтлэг байжээ. Эртний Нангиад оронд "малгай, бүс" хэмээх ойлголт түшмэдийн тушаал ахих, эрх ямба нэмэхийн билгэдэл болдог бол, Перс оронд "малгай, бүс, титэм" гурав нь төрийн билгэ тэмдэг болж байлаа.

Түрэгийн үеийн хүн чулуунд өргөн хэрэглэгддэг дөрвөлжин ялтсан чимэг, зэр зэвсэг зүүхэд зориулсан олон тооны оосор, унжлага Монголын үеийн хүн чулуудад байдаггүй. (3-р зураг) Түрэгийн үеийн хүн чулуудад дүрслэгддэг цэцгэн хээ цаашдын Монголчуудын хүн чулуунд уламжлагдсан байж болох талтай юм. Түрэгийн хүн чулуу, Монголын хүн чулуудад аль алинд нь эмэгтэй хүнийг дүрслэх боловч бүстэй дүрсэлсэн тохиолдол алга байна. Хүн чулуу төдийгүй эмэгтэй хүний булш оршуулганаас ч бүс огт гардаггүй. Эртнээс бүс бол эр хүний хүндэтгэл билгэдлийн зүйл байсны илэрхийлэл болдог бөгөөд эмэгтэй хүнийг бүсгүй хүн гэж нэрлэж ирсэн нь үүнтэй холбоотой юм. Гэхдээ эмэгтэй хүн огт бүс хэрэглэдэггүй байсан гэсэн үг бас биш юм. Эмэгтэй хүний ууж хэдийгээр бүс үгүй боловч ар, өвөр ташаан талдаа оноотой байдаг. Мөн манай эриний XIII зууны дундуур Монголд



Зураг 3. Түрэг, Уйгар, Монголчуудын хүн чулуунд дүрслэгдсэн бүсний хэлбэрүүд

ирсэн жуулчин Гильом Дө Рубрук тэмдэглэхдээ "...эмэгтэйчүүд морь унахдаа хөх торгон бүс бүслэдэг" гэсэн нь бас нэг нотолгоо болж байна.

Археологич С.В.Кисилевийн "... Чита мужийн Хархираа голын Окошка ууланд малтан шинжилсэн XIII зууны үеийн Монголын язгууртны 6-7 настай хүүхдийн шарилд мөнгөн товруутай бүс дагалдуулсан" явдлыг эс тооцвол хүүхдийг оршуулахдаа бүс бүслүүлдэггүй байжээ.

Ном зүй

С.Г.Баталов. За Уралскай Гунний. II-IV вв. н.э

Г.Батнасан. Монгол ардын хувцас. УБ 1989

З.Батсайхан. Агт морь адууны тоног хэрэглэл. (Хүннүгийн хэрэглэгдэхүүнээр)
МУИС-ийн ЭШБ №3 (127), УБ., 1997.

Д.Баяр, Д.Эрдэнэбаатар. Монгол Алтайн хүн чулуун хөшөө. УБ. 1999

Д.Баяр. Монголчуудын чулуун хөрөг. XIII-XIV УБ., 1995.

Д.Баяр. Төв Азийн нүүдэлчдийн исэр суудлын тухай. ТС. 1997.

Д.Баяр. Монголын Төв нутаг дахь Түрэгийн хүн чулуу. УБ., 1997.

Д.Баяр. Алтан ургийн язгууртны нэгэн булшыг судалсан нь. УБ., 1999

БНМАУ-ын түүх. I боть. УБ., 1966.

БНМАУ-ын Угсаатны зүй. I боть. УБ., 1987.

В.В.Волков. Оленные камны Монголии. УБ., 1981.

А.В.Давыдова. Пояс с бронзовым лясками из Дыретуйского могильника.
Советская Археология. 1988.

Ц.Дамдинсүрэн. "МНТ". УБ., 1990.

Дарьгангын сувдан сондор. УБ., 1998.

Б.Б.Дашибалов. Хунны и Курыками. Улан-Удэ., 1996.

В.Ч.Добжанский. Наборные пояса кочевников Ази. Новосибирск., 1990.

П.Карпини. Монголчуудын түүх. УБ., 1988.

В.Д.Кубарев. Древнетуркские изаяния Алтая. Новосибирск., 1984.

Лувсанданзан. Алтан товч. УБ., 1990.

Х.Лхагвасүрэн. Дундад эртний монголчуудын булш оршуулгын зан үйлээс. УБ.,
1994.

Марко поло. Орчлонгийн элдэв сонин. УБ., 1988.

В.Е.Медведев. Опыт в конструкции поясов чжуржэньского времени. Проблемы
реконструкции в археологии. Новосибирск., 1985.

Монгол ёс заншлын их тайлбар толь. тэргүүн боть. УБ., 1992.

Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал. УБ., 1999.

Международная конференция. 100 лет Гуннский археологий. Номадизм
прошлое настоящее в глобальном контексте исторической преспективе Гуннский
феномен. МКСЛАГАНПНГКП, ГФ. I часть.

Д.Наваан. Бага арцатын амны монгол булш. УБ., 19993.

Д.Наваан. Дорнод монголын хүрлийн үе. УБ., 1975.

Д.Наваан. Новые находок "зверного стиля" монголии. Археология и этнография
Монголии. Новосибирск., 1978

Д.Наваан. Ховдын экспедицийн тайлан. 1991

Д.Наваан. Эртний Монголчуудын бүс эрхэмлэх ёсон. ОУМЭ IV IX. III боть. 1986

Д.Наваан. Эртний Монголчуудын түүхийн дурсгалууд. УБ., 1980

Ж.Неру. Ертөнцийн түүхийг сөхөн үзвэл. УБ., 1989.

Э.А.Новгородова. Древняя монголия. М., 1985.

Х.Нямбуу. Монгол хувцасны түүх. УБ., 2002

Х.Нямбуу. Монголын бэлгэдэл. УБ., 1982

Х.Нямбуу. Хамгийн эрхэм ёсон. УБ. 1970.

Х.Пэрлээ. Монголын түүх судлах сурвалжийн нэг нь пайз мөн. Түүхийн судлал.

УБ., 1976.

Соёлын өв хадгалагч.УБ., 1999.

Г.Сүхбаатар. Монголчуудын эртний түүх. УБ.,1980

Г.Сүхбаатар. Сяньби. УБ.,1972.

Н.Сэр-Оджав. Монголын эртний түүх. УБ.,1977.

Н.Сэр-Оджав. Эртний Түрэгүүд. УБ., 1970.

С.С.Тур. Гунны в Среднее Ази. МКСЛАНПГКПГФ. Улан- Удэ. 1996. часть I

Худяков. Ю.С. материалы Хуннского времени в музях. Восточного Туркестана.

МКСЛАНПГКПГФ. Улан Удэ., 1996. часть I

Худяков.Ю.С. Хунны в Саяно- Алтае. МКСЛАНПГКПГФ. Улан Удэ., 1996. часть.I

Д.Цэвээндорж. Монголын эртний урлагийн түүх., УБ.,1999

Д.Цэвээндорж. Чандманы соёл., УБ., 1980.

Д.Цэвээндорж. Чандманская культура. Археология и этнография Монголии.

Новосибирск., 1978.

Шибя Рёотаро. Тал нутгийн тэмдэглэл. УБ., 1997.

Д.Эрдэнэбаатар. Монгол нутгийн дөрвөлжин булш, хиригсүүрийн соёл. УБ., 2002.

Summary

**D.Erdenebaatar
Ts.Odbaatar**

Belt of the nomadic people, it's development

The main archaeological materials of the belt, which was used by ancient nomads are deer stones, petroglyphs, stone statues and archaeological artifacts in Mongolia.

It's clear that nomad's belt was an important commodity for health and madnificence and it can be divided for everyday life, war and decorative etc...

In this article we focused to write about the belt, which was used from Bronzen age to Medieval Mongolian period.